

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 55

- Монголын Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./*
1. 6 – 43
-
- Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.01.02-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./*
2. 44 – 55
-

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 13 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

*Томилолттой: Ш.Бямбасүрэн;
Чөлөөтэй: Х.Баттулга, П.Батчимэг, Ж.Ганбаатар, Б.Найдалаа,
О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: М.Мандхай;
Тасалсан: Ч.Лодойсамбуу.*

Нэг.Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Технологийн албаны дарга Б.Мөнх-Эрдэнэ, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөвлөлтийн инженерийн албаны дарга А.Баяржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Р.Батболд, Б.Жаргалан, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Х.Ганхуяг, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн

сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Р.Батболд, П.Сайнзориг, Б.Мөнхсоёл, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Р.Сэддорж: Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	6
Бүгд:	17

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.01.02-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эрчим хүчний яамны Санхүүгийн хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Эрчим хүчний яамны “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Б.Дашдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, М.Энхцэцэг, Л.Соронзонболд, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эрчим хүчний яамны Санхүүгийн хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Эрчим хүчний яамны “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Б.Дашдаваа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн үг хэлэв.

Р.Сэддорж: Монгол Улс болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 02 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
13 цаг 13 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, А.Ундраа, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг нарын гишүүд ирсэн байна.

Албан ёсоор Х.Баттулга, П.Батчимэг, Б.Найдалаа нар чөлөөтэй. Орон нутгийн томилолттой Ш.Бямбасүрэн гишүүн, эмнэлгийн чөлөөтэй М.Мандхай гишүүн.

Хуралдааны ирц 60 хувьтай байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 60 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх.

Засгийн газраас 2025 оны 01 сарын 08-ны өдөр зөвшилцөхөөр ирүүлсэн.

Хоёр. Монгол Улс болон Олон улсын сэргээн босголтын Хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх.

Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр ирүүлсэн.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монголын Улсын Засгийн газар болон
Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд
байгуулах Зээлийн хэлэлцээрийн төсөл**
/Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх,
санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын
байнгын хороонд хүргүүлнэ./

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банкны хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя.

Зээлийн хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан танилцуулна.

Сайдын микрофоныг нээе.

Ц.Туваан: Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын ЭКСИМ банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг 2017 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Улсын Их Хурлын зүгээс төсвийн төслийн санхүүжилтэд шаардлагатай 1 тэрбум 236 сая ам.долларын зээлийн хэлэлцээрүүдийг 2017, 2019 онуудад соёрхон баталсан.

Төслийн хэрэгжилтийн явцад Монгол газрын тос боловсруулах үйлдвэрээс ЕРС-04 багц буюу үндсэн үйлдвэрийн барилга, байгууламж, газрын тос боловсруулах ажлын төсөвт өртөг нэмэгдэх талаар мэдэгдсэн бөгөөд төслийн өртгийн нэмэгдлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны харьяа Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл 2023 оны 9 дүгээр сард хэлэлцэн төслийн нийт өртгийг 1 тэрбум 698 сая доллар буюу хуучин төсөвт өртгөөс 462.2 сая ам.доллараар нэмэгдэхээр баталгаажуулсан.

Үүний дагуу Засгийн газрын зүгээс газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөлд шаардлагатай нэмэлт санхүүжилтийг Бүгд Найрамдах Энэтхэг

Улсын ЭКСИМ банкны зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр зээлийн хэлэлцээрийг хийгээд байна.

Энэтхэгийн талаас 464.0 сая амдолларын нэмэлт санхүүжилт нь ЕРС-04 багц ажлын хүрээнд зарцуулагдах тул 2019 онд тус багц ажлын хүрээнд байгуулсан 236.0 сая ам.долларын зээлийн хэлэлцээрийг цуцалж, шинээр байгуулах хэлэлцээрийн дүнд нэгтгэснээр нийтдээ 700.0 сая амдолларын зээлийн хэлэлцээр байгуулахаар хэлэлцээрийн төсөлд тусгаад байна.

Зээлийн хэлэлцээрийн төсөлд Энэтхэгийн талаас өмнөх зээлийн хэлэлцээрийн нөхцөлүүдээс гадна дараах 3 нөхцөлийг шинээр тавиад байна. Үүнд:

1.Төслийн хүрээнд дахин нэмэлт санхүүжилт шаардлагатай болсон тохиолдолд Монгол Улсын Засгийн газраас санхүүжүүлэх.

2.Төслийн хүрээнд олох бүх орлого, авлагыг Монгол Улсад орших аль нэг банканд нээсэн “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит компанийн дансаар дамжуулах бөгөөд хэрэв зээлийн хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүргээ Засгийн газар биелүүлээгүй буюу зээлийн эргэн төлөлтийг хийгээгүй дефолтод орсон тохиолдолд “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит компанийн дансыг царцааж, төлбөрийг үйлдвэрийн орлогоос шууд татан авах.

3.Зээлийн хэлэлцээрийн хүрээнд төлбөрийн үүрэг дуусах хүртэл буюу 2040 он хүртэл хугацаанд газрын тос боловсруулах үйлдвэрийн орлогод дарамт үүсэх аливаа асуудалд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын ЭКСИМ банктэй зөвшилцөх зэрэг нөхцөлүүдийг зээлийн хэлэлцээрт тусгаад байна.

Мөн төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай импортоор орж ирсэн тоног төхөөрөмжийг төсөл дуусах хүртэл гаалийн түр горимд байршуулах зохицуулалтыг тус хэлэлцээрийн төсөлд тусгасан.

Нэмэлт санхүүжилтийн зээлийн эх үүсвэр нь өмнөх зээлүүдийн адил жилийн 1.75 хувийн хүүтэй, үйлчилгээний шимтгэл болон хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэл тус бүр 0.5 хувь, 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, нийт 20 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй болно.

Тус зээлийн хэлэлцээр нь Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 14 мега төслийн нэг болох газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг бүрэн хэрэгжүүлж, төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулахад чухал ач холбогдолтой юм.

Тус зээлийн хэлэлцээрийг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн бөгөөд Засгийн газрын

хуралдааны тэмдэглэл, гэрээний төсөл, танилцуулга материалыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Та бүхэн газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэмэлт санхүүжилтийн зээлийн хэлэлцээрийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ц.Туваан сайдад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Ч.Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Алтанцэцэг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал, У.Чинзориг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга, Б.Мөнх-Эрдэнэ “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Технологийн албаны дарга, А.Баяржаргал “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөвлөлтийн инженерийн албаны дарга.

Зээлийн хэлэлцээрийн төслийн талаарх асуулт асуух гишүүд нэрсээ өгье. М.Бадамсүрэн гишүүнээр тасалъя. О.Батнайрамдал гишүүний микрофоныг нээе.

О.Батнайрамдал: Баярлалаа. Сүүлийн бараг 10 жил бид олон мега төсөл гэж ярьсан. Тэр дундаа яг санхүүжилт нь шийдэгдээд явж байгаа том төслүүдийн нэг яалт ч үгүй газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл мөн л дөө.

Тэгэхээр Оюу Толгойгоос харсан ч гэсэн бид нэг зүйлийг сураад байгаа шүү дээ. Томоохон төсөл анхны бодсоноороо хэзээ ч байдаггүй. Тэгээд хойшлох тусам зардал өсдөг, хугацаа алддаг. Хугацаа алдах тусам зардал өсөх нь ойлгомжтой л доо. Энэ Оюу Толгой дээр хамгийн классик жишээ бол энэ мөн шүү дээ.

Гэхдээ бас нэг зүйлийг ойлгох хэрэгтэй байгаа юм.

Ер нь дэлхий дээр явж байгаа томоохон мега төслүүдийг аваад үзэх юм бол цаг хугацаандаа анхны төсвөөрөө хэрэгжсэн төслүүд ер нь ховор талдаа байдаг л даа. Тэгээд энэ чинь маш олон талыг оролцуулж байгаа, олон зүйлээс шалтгаалдаг болохоор.

Тэгэхээр энэ дээр санаа зовж байгаа зүйлүүд байна. Энэ төсөл заавал хэрэгжиж байж Монгол Улсад өгч байгаа ач холбогдол нь зөвхөн эдийн засаг гэлтгүй л дээ. Геополитик цаашаа яригдана. Нэлээн өндөр ач холбогдолтой. Үүнийг бид бүгдээрээ сайн ойлгодог болсон.

Энэ зээлийн хэмжээ нэмэгдэх тусам шууд юун дээрээ нөлөөлж байх ёстой вэ гэх юм бол буцаад бүр анхны хийсэн техник, эдийн засгийн үндэслэл дээр очиж нөлөөлсөн байх ёстой. Ер нь газрын тос боловсруулах үйлдвэр нийтдээ энэ чинь хоолойгоо оруулах юм бол бараг 2.1, 2.2 тэрбум долларын төсөл гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр зээл нэмэгдэхэд техник, эдийн засгийн үндэслэл дээр хэр нөлөө үзүүлсэн бэ? Энэ төсөл дахиад 1.7 тэрбумын зээлээ нэмж аваад нийт дүн нь гарахаар зээлийн хэмжээ техник, эдийн засгийн үндэслэлд хэрхэн нөлөөлж байгаа юм. Нэгдүгээрт,

Хоёрдугаарт, бас нэг санаа зовж байгаа асуудал. Зээлээ бид баталсан ч гэсэн буцаад улсын төсвийн нэгдсэн төсөв дээрээ бас орон зай үүсэж байж энэ нь цаашаа ажил хэрэг болно шүү дээ.

Тэгэхээр бид тэр алдагдалгүй төсөв баталдаг концепц руу сая энэ 2025 оноос эхлээд ороод эхэлчихлээ.

Тэгэхээр сая ч гэсэн бид алдагдалгүй төсөв батлахын тулд нэлээн таналт хийх хүрээнд яг үнэндээ бараг 60, 70 хувь нь хөрөнгө оруулалтын төсвөөсөө танасан шүү дээ. Тэрний нэг нь энэ газрын тос боловсруулах үйлдвэр. Би буруу санаагүй бол 270 тэрбум төгрөг хасагдсан санагдаж байна.

Тэгэхээр дахиад дараа нь төсөв дээрээ орон зай гарахгүй болохоор бид хэчнээн нэмж зээлийн гэрээ байгуулсан ч гэсэн энэ чинь бодит амьдрал дээрээ дахиад л хамгийн том асуудал нь үүсэх байхгүй юу. Дахиад энэ чинь хамгийн гол нь хэрэгжүүлье гэтэл төсөв дээрээ орон зай байна уу, үгүй юу? Энэ хоёр асуулт.

Дарга аа, цагаа сунгачихъя, тэгэх үү? Нэгмөсөн авчихъя.

Гуравдугаарт нь, энэ төсөл цаашдаа бодитоор хэрэгжих үү, үгүй юу гэдэг явж явж одоо яг бид нарын “Петро Чайна”-тай хийх хэлэлцээрээс шууд хамаарна л даа. Яагаад гэхээр бид түүхий тосоо “Петро Чайна”-аас Дачин Тамсагт олборлож байгаа тосоо авах ёстой. 1.5 сая хэрэгтэй. Гэтэл бидэнд Дачин Тамсагийн одоогийн гарц нь 2024 оны гүйцэтгэлээр 552 мянган тонн байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ бодит OUTPUT гуравны хоёроор нэмэгдэх ёстой гэсэн үг байхгүй юу. Нэмэгдэж бүтэн чадлаараа ажиллаж байж энэ яг ТЭЗҮ-гийнхээ хүчин чадлаар энэ төсөл өгөөжийн хувьд ашигтай ажиллана гэсэн үг юм. Энэ

буурах тусам нийт хүчин чадлаараа бид буураад л 50, 60 гэх тусам энэ цаашаа төсөл ашигтай ажиллах уу, үгүй юу. Тэр битгий хэл ажиллуулаад хэрэг байна уу, үгүй юу гэдэг ийм асуудал руу орох учраас энэ давхар зайлшгүй шийдэгдээд явах ёстой.

Тэгэхээр энэ маргааны асуудал Засаг дээр хэр явж байгаа юм болоо? Энэ шийдэгдэж байгаа болов уу?

Р.Сэддорж: Хариулт. Сангийн сайд Болдын Жавхлан. 2 номер уу 3 уу? 3.

Б.Жавхлан: Эдийн засгийн байнгын хорооны дарга, гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

О.Батнайрамдал гишүүний асуултад хариулаад эхэлье.

Төсөвтэй холбоотой асуулт. Яах аргагүй дараагийн сорилт энэ гарч ирнэ. Төсвийн өнөөдрийн бид баримталж байгаа дүрэмд буруу байхгүй. Бид уул уурхайгаас хамааралтай ийм эдийн засагтай. Аль болох савлагааг нь хязгаарлаж явж байдаг ийм дүрэмтэй. Тэр дүрмээс, хязгаарлалтаас гарч халих гээд байгаа л нэг ийм бид том төсөлд байхгүй юу.

Тэгэхдээ үүний том жижиг гэдэг асуудал ашиглалтад орсноос хойш өгөөжтэй нь холбоотой асуудал. Хэрвээ үнэхээр дотоодын хэрэгцээнийхээ 55 хувь буюу өнөөдөр бид 2 тэрбум доллароо гадагшаагаа нефтэд төлж байгаа. Нефтийн бүтээгдэхүүнд.

Үнэхээр энэ ашиглалтад ороод 1 тэрбум доллароо бид гадагшаагаа биш дотооддоо аваад үлдэх юм бол үнэхээр үүнээс том өгөөж гэж бидэнд байхгүй. Ойрын хугацаанд. Нөгөө 14 мега төслийн маань хамгийн эрт өгөөжөө өгч эхлэх бодитой одоогоор эхэлчихсэн байгаа төслүүдийн цорын ганц нь ерөөсөө энэ.

Тийм учраас одоо бид ерөөсөө гарцаагүй үнэхээр EPC-04 /Engineering, Procurement, and Construction/ гэрээ зурагдаж эхэлснээс хойш 38 сарын дараа буюу 3 жил 6 сар.

Ингээд соёрхон баталчих юм бол 02 сарын 05-нд гэрээгээ зурья гэж байгаа. Ингээд 38 сар гэдэг маань 2027 оны үндсэндээ 5 сард байхгүй юу. Ингээд бүтээгдэхүүн гараад эхлэх юм бол үнэхээр болж л байна.

Тэгэхийн тулд харин сая таны хэлдэг энэ сорилт гарч ирж байгаа. Энэ төсвийн дүрэмтэй холбоотой. Энэ жил бид 2025 онд зээлийн ашиглалтад 89 төсөлд зориулж 1.5 их наядын л төсөвтэй байгаа. 89 төсөл шүү. Энэ дотор энэ төсөл маань өөрөө орчихсон явж байгаа. Хамгийн том төсөл нь.

Ингээд 1.5 их наядаас бид бусад төслүүдийг нь бас зогсоож болохгүй. Энэ төсөлд хуваарилж чадах хамгийн дээд хэмжээ нь 350 тэрбум төгрөг.

1.7 тэрбум гэдэг маань яах вэ 286-г нь хасчих юм бол 1 тэрбум 430-аад сая доллар. Энэ нь одоо өнөөдрийн ханшаар 5.2 их наяд төгрөг байхгүй юу. Тэгээд өнөөдрийнхөө дүрмээр жилд 350 гэх юм бол энэ чинь 15 жил үргэлжлэх төсөл болчхож байгаа юм. Өнөөдрийнхөө багтаамжаар явах юм бол, зээл ашиглалтын төсвийнхөө багтаамжаар явах юм бол.

Тийм учраас гарцаагүй Их Хурал маань дэмжээд үүнийг соёрхон баталчих юм бол ашиглалт дээрээ хавар Засгийн газрын зүгээс нэг удаагийн хууль. Үүнийг төсвийн зарлагын хязгаарлалтад зөвхөн энэ төсөлд зориулж, энэ нь өөрөө гадаад эх үүсвэртэй, долларын эх үүсвэртэй зээлд зориулаад нэг удаагийн дүрэм хийхээс өөр аргагүй болж ирж байгаа юм.

Тийм учраас үүнийг эртхэн дуулгаж байх нь зөв. О.Батнайрамдал гишүүн энэ асуудлыг хөндсөнд баярлалаа.

Өнөөдөр бас бүлгүүд дээр ч гэсэн танилцуулга хийхдээ үүнийг зориуд дурдсан байгаа. Үүнийг харин тухайн үед өргөн барихад гишүүд маань үүнийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Тийм.

Р.Сэддорж: 4 номер. Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Шийдвэр нь 2017 онд гараад, 2018 онд техник, эдийн засгийн үндэслэл боловсруулагдсан.

Энэтхэгийн Засгийн газраас олгох 1 тэрбум ам.долларыг газрын тос боловсруулах үйлдвэр лүү ашиглая гээд техник, эдийн засгийн үндэслэл боловсрогдоод 1 тэрбум 236 сая доллароор техник, эдийн засгийн үндэслэл тухайн үедээ батлагдсан.

Энэ ТЭЗҮ-г 5 жил тутамд шинэчилж, дахин нягтлах заалттай байгаа. Тэгээд 2023 оны 9 дүгээр сард газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-д тодотгол хийсэн. Энэ тодотголоор 1 тэрбум 890 сая доллар болох судалгаа гарч ирсэн. Энэ дээр зарлачихсан байгаа тендерүүдийн хамгийн бага үнэ, мөн Энэтхэгийн талтай яриа хэлэлцээрийг хийж байгаад 1 тэрбум 698 буюу 1.7 тэрбум доллар дээр энэ төслийн техник, эдийн засгийн үндэслэл яг өнөөдрийн байдлаар эцэслэсэн.

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. Ц.Туваан сайд. 4 номер.

Ц.Туваан: Тийм. Техник, эдийн засгийн үндэслэл нэмэгдсэн шалтгаанд нэлээд хэдэн шалтгаан байгаа. Энэ дотор хамгийн гол шалтгаан мэдээж КОВИД. Бид ярихаас өөр аргагүй. КОВИД-ын дараа дэлхийн зах зээл дээр ялангуяа өндөр технологи шаардсан тоног төхөөрөмжийн үнэ маш их хэмжээтэй нэмэгдсэн асуудал байгаа.

Дээрээс нь манай талаас ТЭЗҮ дээр технологийн зарим байгууламж. Тухайлах юм бол онгоцны түлшний гарцыг 40 мянган тонн, өндөр октантай авто бензиний гаралтыг 60 мянган тонноор нэмэгдүүлэх гэх мэт шийдвэрийг оруулсантай холбогдуулж тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнийг агуулах савтай холбогдуулж техник, эдийн засгийн үндэслэл нэмэгдсэн асуудлууд байгаа. Дахиад ч нэмэгдэх тооцооллууд гарч ирсэн байгаа.

Р.Сэддорж: Ц.Туваан сайд нэмж хариулъя. 4 номер.

Ц.Туваан: “Петро Чайна Дачин Тамсаг” компанитай бүтээгдэхүүн хуваах гэрээтэй ажилладаг.

Тэгээд энэ бүтээгдэхүүн хуваах гэрээнийхээ дагуу Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсон тохиолдолд Монголын талынх мэдээж тодорхой. Хятадын тал буюу заалтаараа “Петро Чайна Дачин Тамсаг” компани бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ногдох хэсгээ Монголын талд зах зээлийн үнээр борлуулах гэрээтэй байгаа.

Р.Сэддорж: Тодруулах уу? О.Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Гэхдээ сайд. Би асуугаад байгаа нь техник, эдийн засгийн үндэслэл дээр зардал нэмэгдээд. Яах вэ, OUTPUT бол 100 мянган тонноор нэмэгдэж байгаа юм байна. Тийм ээ?

Тэгэхээр бид чинь 1.5 сая тонн түүхий газрын тос боловсруулна гэж байгаа нь 1.6 л болно байх гэж бодож байна л даа. Гэхдээ техник, эдийн засгийн үндэслэл дээр хамгийн гол нь тэр ашигтай ажиллаж байна уу, үгүй юу гэдэг нь гарсан л байх ёстой л доо. Тэр IR_[Investor relations]-аар нь гарсан юм уу? Тийм ээ. IR-аар нь хэр нөлөө үзүүлж байгаа юм бол оо.

Тэгэхээр тэр чинь буцаад энэ төсөл цаашдаа урт хугацаандаа тогтвортой явах уу гэдгийг тодорхойлно шүү дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Б.Жавхлан сайд ойлгож л байна л даа. Хамгийн гол нь буцаад бид энэ зээлийн хэлэлцээрийг баталчихлаа. Гэхдээ тэгээд буцаад л төсвийн орон зай байж тэр чинь буцаад л хэрэгжинэ шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр дараа нь хэрэгжээд явахад хамгийн гол нь бид ялангуяа ийм алдагдалгүй төсөв баталдаг концепц руу орчихсон үед энэ чинь.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт. 3 номер. Сангийн сайд.

Б.Жавхлан: Харин тийм ээ.

Тэгэхээр одоо 5.2 их наядыг чинь 3 жилд хуваахаар 1.7 орчим их наяд байхгүй юу. Зөвхөн нэг төсөл дээр шүү дээ.

Гэтэл одоо бид 89 төсөлд зориулаад 1.5 их наядын орон зай гаргачхаад 2025 онд ингээд явж байгаа. Бид яах вэ 2.2 гэж түүхэндээ байхгүй л хамгийн том тоо, дүн барьж орсон. Энэ маань 1.5 болоод багасчихсан.

Сүүлийн жилүүдэд энэ дүрмээ бид бариад ер нь 1.2-оос хэтрүүлж чадахгүй явсан юм. Орон зай нь ерөөсөө л ийм байсан юм.

Тэгэхээр яах вэ, энэ удаа тэр дүрмийн буруу бол байхгүй. Дүрэмд ямар ч буруу байхгүй. Гол нь төсөл маань өөрөө бага биш төсөл учраас гарцаагүй л одоо бидэнд ийм шаардлага орж ирж байна.

Тийм учраас төсвийн орон зай гэхээсээ илүүтэй энэ зээлээр санхүүжилтийн нэг давуу тал нь ийм байхгүй юу. Энэ одоо юу гэдэг юм, боловсролын салбарын салбарын ч юм уу, эсвэл эрүүл мэндийн салбарын шууд урсгал зардал, эх үүсвэргүй урсгал зардал бол биш. Энэ гаднаас нь эх үүсвэр нь доллар нь орж ирээд манай төрийн санд доллароороо бүртгэгдээд, доллар нь доллароор, төгрөг нь төгрөгөөрөө зарцуулагдаад явдаг учраас.../минут дуусав/

Р.Сэддорж: Нэмж хариулъя. 3 номер. Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тийм. Тэгээд төлбөрийн тэнцэл дээрээ дарамт багатай. Тэр мөнгөн урсгалаараа.

Тийм учраас үнэхээр 3 жилийн дараагаас өгөөжөө өгөөд жил бүр тэрбум долларыг бид нарт хадгалж авч үлдээд яах юм бол үүнээс сайн төсөл байхгүй л байгаа юм л даа. Ойрын жилүүдэд.

Тийм учраас нэг удаагийн, юу гэдэг юм зардлын өсөлтийн хязгаарт зөвхөн энэ төсөлд бид тооцохгүй, хамааруулахгүй ч гэдэг юм уу ийм практикууд олон улсад байдаг. Жишээ нь, Чили Улс байна. Манайхтай ижилхэн уул уурхайгаас нэлээн хамааралтай. Тэгээд далайн эргийн дагуу байдаг учраас байгалийн гамшигт их өртдөг юм билээ. Энэ далайн.

Тийм учраас түүндээ зориулсан, тэр гамшиг, эрсдэлийг бууруулах зардлаа жил болгон төсөв дээрээ тавьдаг. Тэгээд үүнийгээ алдагдалд тооцдоггүй. Зардлын хязгаартай тооцдоггүй байх жишээтэй. Иймэрхүү туршлага олон улсад байгаа.

Тийм учраас хэдүүлээ онцгой ийм үр өгөөжтэй төсөл учраас нэг удаа хууль батлаад, тодорхой хугацаанд төсөл хэрэгжээд дуусах хүртэл үүнийгээ төсөвтөө яаж ийгээд багтаах ийм хувилбар луу явах нь зүйтэй байх.

Тэр тохиолдолд заавал төсвийн тодотгол.../минут дуусав/

Р.Сэддорж: Р.Батболд гишүүн.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе. Та бүхэнд.

Энэтхэг Улсын ЭКСИМ банкнаас авч байгаа, анх 1 тэрбум долларын зээл л байсан. Тийм ээ. Тэгээд ЕРС-01, 02, 03, 04 гээд төслүүд хэрэгжиж байгаа юм байна гэж ойлголоо.

Тэгэхээр ЕРС¹ нь ерөнхийдөө 203.2 сая доллароор 100 хувь хийгдээд дуусчихсан гэж ойлголоо. Энэ дээрээс. Мөн үү? Энэ РРТ дээр. Тийм. ЕРС-01.

Тэгэхээр ер нь бол яах вэ, бид 1 тэрбум доллароор 4 жилийн өмнө газрын тос боловсруулах үйлдвэртэй болох байсан гэж ойлгоод байгаа. Одоо тэгээд 700-г нэмээд авна.

Яах вэ, нэмж аваад үүнийгээ дуусгах хэрэгтэй. Энэ бол бид нарт Монгол Улсад маш их хэрэгтэй төсөл учраас үүнийг дэмжээд явуулах байх. Хамгийн гол нь одоо бид яг хэдий хугацаанд үүнийгээ барьж дуусах юм бэ гэдэг асуудал байгаа.

Тэгээд ЕРС-02, 03 чинь 15-аас 20 хувийн гүйцэтгэлтэй яваад байдаг. Энэ яг ер нь хэзээ дуусах юм? Мөнгө нь байгаад байгаа юм шиг харагдаад байна.

Тэгэхээр яагаад ажил ингэж хойшлоод удаашраад байдаг юм бэ? Энэ ер нь яг хэзээ дуусах юм? 700-гаа авчхаад ЕРС-04 чинь өөрөө ЕРС-02, 03-тайгаа зэрэг дуусах юм уу, дуусахгүй юм уу гэдэг нэг асуудал байгаад байна. Нэгдүгээрт нэг ийм асуудал асуучихмаар байна.

Р.Сэддорж: Асуулт. 4 Номер. Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Р.Батболд гишүүний асуултад хариулъя.

Энэ өөрөө тэрбум доллар биш. Энэтхэгийн Засгийн газар хоёр улсын Засгийн газар хоорондын хэмжээ нь 1 тэрбум доллар. Зарцуулах шийдвэр нь газрын тос боловсруулах үйлдвэр барья гэдэг шийдвэр гараад техник, эдийн засгийн үндэслэл хийгээд анхны ТЭЗҮ-гээр 1 тэрбум 236 сая доллароор батлагдсан.

Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ анхны техник, эдийн засгийн үндэслэл нь ийм дүнтэй. Одоо 1.7 гэж байгаа. Энэ дээр зөрүү нь 462 орчим сая доллар байгаа. Тэгэхдээ мэдээж үүнийгээ ЕРС-04-ийнхөө хүрээндээ нийлүүлээд 700 сая доллар гэдэг байдлаар оруулж ирж байгаа. Яг жинхэнэ нэмэгдэл нь 460 хэдэн сая доллар байгаа гэдгийг хэлье.

¹ Инженерийн ажил, худалдан авалт, барилгын /engineering, procurement and construction-EPC/ гэрээ ([түлхүүр гардуулах](#) гэрээний нэг төрөл) нь томоохон, нарийн төвөгтэй дэд бүтцийн төслүүдэд барилгын ажил гүйцэтгэх гэрээний нэг хэлбэр.

- ▶ ЕРС-01-ийн ажил **100** хувь гүйцэтгэсэн.
- ▶ ЕРС-02 өнөөдрийн байдлаар **22.7** хувьтай.
- ▶ ЕРС-03 **13.0** хувьтай.
- ▶ ЕРС-04-ийг бид хэрэгжүүлэх тендерээ зарлаад шалгаруулчихсан.

Одоо түүндээ өгөх төлбөрийн асуудлыг Энэтхэгийн ЭКСИМ банкттай 1.6 жил хэлэлцээд зөвшөөрүүлсэн шийдвэрийг аваад, одоо энэ зээлийнхээ хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулахаар оруулж ирж байгаа юм гэдгийг хэлье.

Тэгэхээр хамгийн урт хугацаа энэ зээл соёрхон батлагдсанаар, энэ шугам нээгдсэнээс хойш 36-аас 38 сарын дараа үйлдвэр бүрэн ашиглалтад орохоор байгаа.

Тэгэхээр бусад ЕРС-02, 03 бол хугацаагаараа гүйцэтгэгдээд 100 хувь ашиглалтад орно гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Р.Батболд гишүүн тодруулж асууна.

Р.Батболд: ТЭЗҮ-ээрээ 1 тэрбум 236 байсан гэдгийг ч мэдэж байгаа. Одоо 464-ийг нэмэх гээд. Энэ хугацаа алдсанаас л болоод байна л гэж ойлгоод байна л даа.

Тэгэхээр одоо яг л хугацаандаа үүнийгээ хийж чадах уу гэдэг л гол асуудал байгаад байгаа юм. Тэгээд дахиад л нэг, хоёр жилийн дараа юм уу, нөгөө 36 сарынхаа дараа дахиад 400.0 сая хэрэгтэй болчихсон шүү дээ гээд дахиад нэг ийм юм орж ирэхгүй биз дээ гэдэг зүгээр нэг ийм л болгоомжилсон л юм асуух гээд байгаа юм.

Дахиад нэг асуулт нь. О.Батнайрамдал гишүүний асуугаад байгаа тэр л байна л даа. Бид өөрсдийнхөө эх үүсвэрээр түүхий эдээ яаж хангах юм бэ гэдэг.

Энэ дээр аль зэрэг, хайгуулын ажил нь яаж явж байдаг юм. Дахиад нэмээд тэр олборлолт нь ч юм уу, нэмэгдүүлэх. Түүхий эдээрээ өөрсдөө 100 хувь хангачих боломж нь ямар байгаа бол? Ямар ажил хийгдэж байгаа бол? Үүнийг Ц.Туваан сайд та хариулж өгвөл.

Р.Сэддорж: 3 номер. Б.Жавхлан сайд. Дараа нь 4 номер. Ц.Туваан сайд.

Б.Жавхлан: Р.Батболд гишүүний асуултад хариулъя.

Хугацааны хувьд үнэхээр эрсдэл үүссэн. Тэгэхдээ энэ хугацааны эрсдэл дотоодоос шалтгаалаад байгаа хүчин зүйл нь маш бага.

Анх 2017 онд тэрбум доллар гээд зөвхөн зээл санал болгосон. Бидэнд. Бид юу хийхээ ярилцаж байгаад сая хэллээ. Энэ төслөө хийе гээд ТЭЗҮ-гээ хийтэл 1 тэрбум 286.

Ингээд 2019 оноос ЕРС-01 эхэлсэн юм. Эхэлмэгц ерөөсөө хагас жилийн дараа КОВИД тулсан. Ингээд ерөөсөө эхлүүлж чадаагүй. Эхлүүлж чадаагүй. ЕРС-02, 03 бол дөнгөж 2023 онд эхэлсэн шүү дээ.

2023 онд эхлэх гэтэл бас гэрээн дээр асуудал үүссэн байгаа. Өмнөх ЕРС-01-тэйгээ уялдуулаад ч юм уу, эсвэл бүр хамгийн том тулчихсан хүнд асуудал нь ингэсэн. 2019 онд зээлийн тоолуур эхэлчхэж байгаа юм. Гэтэл 2023 онд дөнгөж 120 сая доллар хэрэглээд явж байтал анхны гэрээгээрээ 64 сая долларын үндсэн гэрээний төлбөрийн хугацаа нь болчихсон, 2023 онд.

Р.Сэддорж: Б.Жавхлан сайд нэмж хариулъя. 3 номер.

Б.Жавхлан: Нөгөө КОВИД-ыг чинь тэгээд дайраад өнгөрч байгаа шүү дээ. Тэгээд одоо юу ч хийж чадаагүй ЕРС-02, 03 нь нэг чулуу ч тавиагүй байхад үндсэн зээлийн төлбөр нь эхэлчихсэн.

Ингээд энэ зээлийнхээ нөхцөлүүдийг янзлахгүй бол цаашаага төсөл үргэлжлэх ямар ч боломжгүй болсон. Ингэхийн тулд гэрээг ЕРС-01, 02, 03, 04 гэж задалсан. Өөрөөр хэлбэл 4 фронт тэр зэрэг санхүүжилтүүдээ аваад, бие биеэсээ хамааралгүйгээр бүтээн байгуулалтуудыг цаг хожоод эхлүүлэх ийм шаардлагатай болоод гэрээний тохиргоогоо хийж чадсан байгаа. 6 сар үргэлжилсэн хэлэлцээрийн үр дүнд.

Үүнийг хугацаа алдсан гэж хэлмээргүй. Харин бид ирээдүйд учирч болох хугацааны эрсдэлээ энэ дээр хожиж чадсан байгаа.

2023 оноос эхэлж үндсэн төлбөрүүд эхлэх байсныг бид 2029, 2030 он хүртэл хойшлуулж чадсан байгаа. Тэгээд энэ хүрээнд ЕРС-04-ийнхөө сүүлийн гэрээ хийгдэх ёстой.

Тэгэхдээ энэ нэмэгдэж байгаа дүн зөвхөн ЕРС.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. 3 номер.

Б.Жавхлан: Энэ чинь зөвхөн ЕРС-04 биш байхгүй юу. Одоо

- ▶ ЕРС-01 нь 12.9 сая доллар,
- ▶ ЕРС-02 нь 233.0 сая доллар,
- ▶ ЕРС-03 нь 82.7 сая доллар,
- ▶ ЕРС-04 нь 137.0 сая доллар.

Ингээд нийтдээ **464.0** сая долларын гэрээний нэмэгдэл орж ирж байна гэж ойлгох хэрэгтэй. Тийм.

Р.Сэддорж: Б.Жаргалан гишүүн асуулт асууна. Уучлаарай. Хассуурийн Ганхуяг гишүүнийг асуулт дээр нэмээрэй. Одоо Ц.Туваан сайд үргэлжлүүлж хариулна. 4 номер.

Ц.Туваан: Р.Батболд гишүүний асуултад гүйцээж хариулъя.

Монгол Улс яг өнөөдрийн байдлаар XIX, XXI талбайн геологийн баталгаат нөөцөөр 300 гаруй сая тонны нөөц батлагдсан ордтой.

Яг ашиглалтын баталгаат нөөц гэж бас байдаг. Үүнийг 41 сая тонн нь энэ талбай дээр батлагдсан. Үүнээс 10 орчим сая тонныг олборлоод экспортод гаргасан. Одоо 31 сая тоннын ашиглалтын баталгаат нөөцтэй явж байгаа.

Хамтарсан Засгийн газар үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 6 талбай дээр талбай зарлаж бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулаад явж байгаа. Өнөөдрийн байдлаар **“Петро Чайна Дачин Тамсаг”**, **“Доншин”**, **“Петро Матад”** зэрэг компаниуд олборлолт хийж байна.

Тэгээд энэ талбайнууд дээр компаниуд орж ирж нөөц нэмэгдэх ийм.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулах уу? 4 номер. Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Яг өнөөдрийн байдлаар 2024 оны гүйцэтгэлээр 550 мянган тонн түүхий тос олборлосон ийм дүн мэдээ гарсан.

Бид бүхэн 2014 оны үед 1.1 сая тонн түүхий тос олборлож байсан ийм түүхтэй.

Тэгэхээр бид бүхэн 1.5 сая тонноо олборлох боломжтой гэж үзэж байгаа. Дээрээс нь энэ дээр олборлолт хийж байгаа компаниуд дээр дотоодын, ялангуяа татварын маргаантай асуудал, данс хаах, мөн бусад хүндрэлүүдийг хүндрэлүүдийг арилгаж чадвал энэ компанитай бид Монгол Улсын Ерөнхий сайдын хэмжээнд хүртэл энэ компанийн удирдлагуудтай уулзаад явж байгаа.

Тэгээд хамтын ажиллагаагаа өргөжүүлээд, хөрөнгө оруулалтыг нь нэмэгдүүлж чадсан тохиолдолд энэ олборлолтын хувь дээшлээд 1.5 сая тоннд үйлдвэр ашиглалтад орох хугацаанд хүргэх боломжтой гэж үзэж байгаа.

Р.Сэддорж: Б.Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Мэдээж хэрэг Монгол Улсын хувьд нефтээ өөрсдөө боловсруулдаг болох, шатахуун үйлдвэрлэдэг болох зорилт бол маш том зорилт байгаа. Тийм ээ. Бид үүнийг хүсэж хүлээж мөрөөдөж ирсэн.

Тэгээд Энэтхэгийн Засгийн газартай анх гэрээ байгуулагдсанаар ойрын хугацаанд энэ мөрөөдөлдөө хүрнэ гэсэн хүлээлт байсан боловч анх энэ төсөл яригдаж эхэлснээс хойш, 2017 оноос хойш даруй 8, 9 жил өнгөрчхөж байна.

Тэгээд төсөл хэрэгжиж эхэлсэн хугацааг түрүүн танилцуулахдаа 2017 оны 04 сарын 04 гэж байна. Тэгээд анхны ТЭЗҮ-г нь 2018 онд батлаад, тэгээд түүнээс хойш зээлийн эх үүсвэрээс 268.6 сая ам.доллар зарцуулчихсан байгаа юм байна.

Тэгээд одоо энэ зарцуулагдсан хөрөнгөөр хийгдсэн зүйл яг юу байгаа вэ? Одоо ингээд очоод үзэхээр үзэж харах зүйл юу байна вэ? Нэгдүгээр асуулт.

Өнгөрсөн хугацаанд ер нь ажил яагаад удааширсан бэ? Яах вэ, сая Б.Жавхлан сайд зээлийн гэрээтэй холбоотой, КОВИД-той холбоотой гээд асуудлуудыг тоочиж байна л даа. Гэхдээ ер нь цаашид энэ хүчин зүйлүүд бас илаарсан уу, үгүй юу? 36 сарын хугацаанд бид энэ төслөө дуусгах боломжтой эсэх дээр яг нэг бодит дүгнэлт хэлмээр байна.

Тэгээд одоо ингээд анхны техник, эдийн засгийн үндэслэлээс төслийн өртөг 464.0 сая ам.доллараар нэмэгдсэн гэсэн зүйл оруулж ирээд Улсын Их Хурлаар зээлийн хэлэлцээрийг соёрхон батлуулах хүсэлт тавьж байна.

Тэгэхээр нийтдээ энэ төсөл маань 1 тэрбум 700 сая ам.долларын төсөл болох гэж байна. Тийм ээ. Тэгээд дээрээс нь Эрдэнэс Тавантолгойн 377.0 сая ам.доллараар бас хийн хоолой барьчихсан байгаа. Энэ хийн хоолойн ажил бас яг ямар хувьтай яваа вэ? Хэдэн төгрөг зарцуулагдсан байгаа вэ?

Тэгээд Улсын Их Хуралд зээлийн хэлэлцээрийг оруулж ирэхдээ зөвхөн ЭКСИМ банктэй холбоотой хэлэлцээрийг л оруулж ирлээ. Тэгээд төслийн техник, эдийн засгийн үндэслэл, нэмэгдсэн дүн, яагаад нэмэгдсэн бэ, мөн гүйцэтгэгч компаниудын мэдээлэл гэх мэт зүйл аягүй дутмаг байна шүү.

Тэгэхээр энэ дээр тодорхой мэдээллүүдийг гишүүдэд өгвөл сайн байна. Тэгээд одоо энэ 36 сарын хугацаанд төслийн бүтээн байгуулалтыг дуусгахын тулд ер нь яг ямар хэмжээний объёмтой ажил хийгдэх юм бэ? Хэдэн гүйцэтгэгч ажиллах юм бэ? Үүн дээр дотоодын зах зээл дээр хэдэн төгрөг нь шингэх юм бэ? Одоо энэ зээлийн нийт объёмоос.

Мөн гаднаас ажиллах хүчин орж ирэх юм уу? Гаднаас зээл нь бүтнээрээ доллараар орж ирэх юм уу, эсвэл тоног төхөөрөмж энэ тэр гэсэн өөр зүйлүүд бас байгаа юм уу гэх мэтчилэн нарийвчилсан мэдээллүүдийг өгөхгүй бол

өнгөрсөн хугацаанд бид төслийн бүтээн байгуулалт хойшлоод яваад байгаа л гэсэн ийм л ойлголттой л байна.

Р.Сэддорж: Хариулт 5 номер.

Д.Алтанцэцэг: Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2017 оны 9 сарын 07-ны өдрийн гэрээгээр байгуулсан байдаг. Газраа сонгоод, усны судалгаа хийгээд эхэлсэн.

Техник, эдийн засгийн үндэслэл 2018 оны сүүлээр дууссан боловч бүрэн хүлээлгэж өгсөн хугацаа нь 2019 оны 2 сар байдаг. Ингээд техник, эдийн засгийн үндэслэлээр Монгол Улсад хэрэгтэй, үр өгөөжтэй, хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлт гарсан.

Тэр дагуу бүх том төслүүдийн нэгэн адил төслийн менежментийн зөвлөхөө сонгон шалгаруулах ажил явагдаад 2019 оны дундуур Төслийн менежментийн зөвлөх компанитайгаа гэрээ байгуулаад энэ компани үйлдвэрийн патенттайгаас бусад бүх технологийн байгууламжууд, дагалдах туслах байгууламжуудын зураг, төслийг боловсруулахад чиглэсэн.

Ингээд 2020 оны 01 дүгээр сараас гүн боловсруулалтын технологийн лиценз эзэмшигчдийн сонгон шалгаруулах ажил явагдсан.

Манай үйлдвэрийн гүн боловсруулалтын технологийн лиценз эзэмшигчид нь Америкийн Нэгдсэн Улсын “Ю Оү Пи” /Universal Oil Products, **Honeywell UOP**/ Францын “Аксенс” /**AXENS** Solutions/ Италийн “Кинетикс техноложи” /**Kinetics Technology**/ Холландын “Шелл” /**Shell Global** International B.V/ компаниуд байдаг.

Энэ компаниуд өөрсдийнхөө байгууламжуудын зураг төслийг. Ерөнхий зураг төсөл байна шүү. Бүрэн боловсруулж 2022 оны сүүл гэхэд хүлээлгэж өгсөн.

Түрүүн манай сайд нар ярилаа. Энэ төсөл хүндрэлтэй, геополитик болоод дэлхий дахиныг хамарсан цар тахлын хямралтай, хүндрэлтэй он жилүүдэд явагдаж байгаа.

Бусад төслүүдийг хэрэгжүүлж байгаа байгууллагууд Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимаас давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ авсан байгаа. Гэхдээ бид тасралтгүй явуулсан.

ЕРС-01 дүгээр ажлын гэрээг 2020 оны 10 сарын 02-нд байгуулж, ажлыг албан ёсоор 2021 оны 01 сарын 15-нд эхлүүлсэн.

Энэ 268 саяыг юунд зарцуулсан бэ гэх юм бол үйлдвэрийн талбай дээр ЕРС-01 дүгээр багц ажлын хүрээнд баригдсан иргэний 11 барилга, зам талбай, хоолойн сувагчлалын ажлууд, дээрээс нь 89.9 километр урттай усны шугам хоолой, түүнийг дагасан цахилгаан дамжуулах агаарын шугам, усны нөөцийн сав 30 мянган метр кубын багтаамжтай гэх зэрэг зүйлүүдийг барьсан.

Энэ 203 бол тэр 01 дүгээр зээлийн багц боловч ЕРС-01 багцын гэрээний үнийн дүн биш байгаа юм. ЕРС-01 багцын ажил чинь 97.8. Энэ 203 юунаас тогтож байна гэхээр нэгдүгээрт:

- ▶ ЕРС-01 ажил **97.8** сая,
- ▶ Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ **73** сая,
- ▶ Лиценз эзэмшигчдийн 4 янзын гэрээ байгуулдгийн 2 нь **29** сая,
- ▶ Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсан **1** сая **450** мянган доллар.

Эдгээрээс бүрдэж байгаа юм. Зарцуулалт нь тийм гэсэн.

Яагаад удааширсан гэхээр удааширсан 2 шалтгаан байгаа.

Нэгдүгээрт, эдийн засгийн шалтгаан байгаа. Бүгд мэдэж байгаа. Хаана чиг л ийм юм тохиолдсон.

Хоёрдугаарт, техникийн шалтгаан байгаа. Энэ нь үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд авч үздэггүй инженерчлэлийн үе шатад бүх үйлдвэрийн нарийвчилсан инженер, технологийн ажлууд хийж эхлэхэд зайлшгүй шаардлагатай нэмэлт тоног, төхөөрөмжүүд, аюулгүй ажиллагаа, тоног, төхөөрөмжийн эдэлгээг уртасгах, ирээдүйн үйлдвэрийн үр ашгийг сайжруулах чиглэлээр зайлшгүй хийгдэх ёстой ажлууд байсан.

Түрүүн Ц.Туваан сайдын хэлсэн хоёр янзын бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх. Энэ бол бас сорил. Ингээд техникийн талаас бол бид байгаль орчин. Монголд ганцхан одоо жишээ нь нэг запас сэлбэг дутлаа гэхэд аваад ирэх тийм газар зах зээл байхгүй учраас бид эдэлгээг хамгийн максимум уртасгах зорилгоор зарим материал, нэмэлт тоноглол тавьж байгаа.

Энэ бол дамжуулах хоолойн хувьд ярья. Түүхий тос дамжуулах хоолой. Хийн хоолой биш.

Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь газрын тосны “Тосон-Уул-ХІХ” талбайгаас үйлдвэрийн талбай.../минут дуусав/

Р.Сэддорж: Өөрийгөө танилцуулаарай. Хэн билээ? 5 номер. Гүйцээж хариулъя.

Д.Алтанцэцэг: Миний нэр Дашдаваагийн Алтанцэцэг. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирал.

Түүхий тос дамжуулах хоолой бол 530 километр. XIX талбайн Дачин компанийн олборлолтын байгууламжтай холбогдсон.

Тэгээд хүлээн авах, илгээх 2 станцтай. Дундаа өргөх шахах 4 станцтай.

Энэ хоолойн ажлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас олон улсад нээлттэй тендер шалгаруулж шалгарсан компани нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “**NORINCO International**” гэж компани байдаг. Тэр компани нь 2023 оны 7 сараас ажлаа явуулаад, одоо гүйцэтгэл ер нь 80-аад хувьтай явж байгаа.

Ер нь дутуу гүйцэтгэлтэй явж байгаа ажлууд станцуудын барилга байгууламжийн ажлууд байгаа. Нэг станц 11-ээс 13 барилга байгуулагдана.

Энэ ажилд EPC-04 ямар объёмтой ажил юм гэхээр гүн боловсруулалтын 7 байгууламж байгаа. Тус тусдаа нэг нэг үйлдвэр шиг гэж ойлгож болно.

Устөрөгчийн байгууламжаас бусад нь бүгдээрээ.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт авлаа. Б.Жаргалан гишүүн хариулт авчихсан гэж ойлголоо. Тийм ээ.

Ж.Алдаржавхлан гишүүн асуулт асууна.

Ж.Алдаржавхлан: Нэг энгийн нэг хэдэн өгүүлбэр хариулчхаарай. Иргэдэд би бас энэ мэдээллийг өгөх гээд байгаа юм.

Нэгдүгээрт, энэ үйлдвэр маань барилгын ажил, төслийн ажил маань яг хэдэн хувьтай явж байна гэж. Одоо бүхэлд нь 100 хувь гэж о ашиглалтад орохыг үзэх юм бол нэгт хэдэн хувьтай явж байна вэ гэдэг асуултыг хариулж өгөөрэй.

Хоёрдугаарт, энэ нефтийн үйлдвэр бол монголчуудын хүслийн жагсаалтын бүр хамгийн тэргүүнд байгаа. Монголчууд чинь ер нь нефтийн хараат байдлаас, бензиний хараат байдлаас гаръя гэж бараг түмэн үеэрээ л хөөрхий бодож байгаа.

Тэгэхээр энэ бидний хувьд одоо хамгийн чухал төсөл байгаа учраас энэ ард түмэнд ойлголт өгөх үүднээс яг хэдэн хувьтай явж байна вэ.

Хоёрт, яг хэзээ орох вэ гэж. Хоёрт, яг хэзээ орох вэ?

Гуравдугаарт, тэрбум 200 сая долларын анх зээлийн хэлэлцээр байж байгаад одоо ингээд өртөг нь өсөж байгаа юм байна. Яг бодитой өссөн үү, үгүй юу гэдгийг та хэд хөндлөнгийн янз бүрийн байгууллага руу шалгуулж үзсэн үү? Тэр төсвийн өртөг бодитой өссөн юм уу гэж.

Дөрөвдүгээрт, 268 сая доллар хэрэглэчихсэн байна гээд байна шүү дээ. 38 билүү. Тэгээд энэ тэрбумыгаа дуусгаж байгаад дараачийнхаа зээлийг авч болдоггүй юм уу? Одоо энэ чинь дахиад л хүүтэй мөнгөний асуудал яригдана.

Одоо 268-ыг 5 жил хэрэглэсэн улсууд чинь үлдсэн 700 орчмыг жил орчим, 2 жил хэрэглэснийхээ дараа дутагдаж байгаа санхүүжилтийнхаа асуудлыг авч болохгүй юу гэж.

Би буруу ойлгож байж магадгүй шүү. Та хэд тойруулаад өгчхөөрэй.

Тэгээд та хэд чинь одоо ингээд харахаар оффис энэ тэр гээд тийм иргэний барилга руугаа аймаар хүчээ тавьчихсан, бариад дуусгачихсан. Үйлдвэр лүүгээ маш бага хүч тавьсан байна. Эхлээд тэр үйлдвэрийн барилгаа барьж болоогүй юм уу? Тэгээд ийм амархан одоо тийм иргэний зориулалттай барилгууд руугаа 100 хувь бариад дуусгачихсан байна.

Тэгэхээр энэ яагаад тэрийгээ эрэмбийг нь тэгж оруулсан юм бэ? Эхлээд үйлдвэр лүүгээ бүх хүчээ яагаад тавиагүй юм бэ гэсэн ийм хэдэн асуултад хариулж өгөөч. Дараа нь би нэмэлтээр асууя.

Р.Сэддорж: 4 номер. Ц.Туваан сайд хариулна.

Ц.Туваан: Энэ үйлдвэр. Бүхэлдээ түрүүн хэлсэн. “Инженерчлэл, барилга угсралт, худалдан авалт” буюу ЕРС гээд 4 багц болгож хуваасан байгаа.

Тэгээд энэ 4 багц ажлынхаа хүрээнд

- ЕРС-01 бол **100 хувь**,
- ЕРС-02-ын ажил **22.7 хувь**,
- ЕРС-03-ын ажил **13 хувь**,
- ЕРС-04-ийн ажил эхлээгүй байгаа.

Ийм байдалтай яг тодорхой хувиар. Энэ дээр нэмэгдэж орсон нэг ажил бол энэ дамжуулах хоолойн ажил байгаа. Энэ дамжуулах хоолойн ажил бол 81.8 хувьтай гүйцэтгэгдээд явж байгаа гэж хариулъя.

Бензиний хараат байдлаас гарах. Энэ бол Монгол Улсын хувьд үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал. Яг өнөөдрийн байдлаар 2024 оны гүйцэтгэлээр Монгол Улс 2.5 сая тонн нефть бүтээгдэхүүнийг импортоор худалдаж авсан. Үүний 95-аас 96 хувийг нь Оросын Холбооны Улсаас, үлдсэн

хувийг нь бусад улсаас худалдаж авсан. Нийтдээ 1.9 тэрбум америк доллар зарцуулж авсан ийм дүн гарсан.

Энэ газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор бид жилдээ Монгол Улсын хэрэглээний 55 хувийг хангах, дээрээс нь 4.5 их наяд төгрөгийн борлуулалт хийнэ гэсэн төлөвлөгөө гарган ажиллаж байгаа.

Түрүүний техник, эдийн засгийн үндэслэл бол мэдээж одоо манайд байгаа бүтэц буюу манай яамны харьяанд байдаг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 9 сарын хурлаар хамгийн сүүлийн тодотголыг оруулсан.

Тэгээд энэ дээр тодорхой Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гарч үнийн өсөлтийг гаргаж өгсөн гэж хэлье.

ТЭЗҮ-гийн тодотголд хөндлөнгийн байгууллагын дүгнэлт одоогоор хийлгээгүй байгаа. Тэгээд Б.Жавхлан сайд.

Р.Сэддорж: Энэ хэллэгээ. Энэ чинь шууд ард иргэдэд ойлгомжтой шууд явж байгаа шүү дээ. Энэ юунуудыг чинь бас ойлгохгүй шүү дээ. Хүмүүс. EPC-01, 02, 03, 04 гэдгээ.

Үүнийгээ яг дэлгэрэнгүй яриад яавал нийт иргэдэд бас ойлгомжтой юм болов уу гэж бодож байна. Б.Жавхлан сайд. 3 номер.

Б.Жавхлан: Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Би түрүүн ярьсныгаа дахиад нэг жоохон дэлгэрүүлээд ярьчихъя. Анх нэг гэрээ хийчихсэн байсан юм. Гэтэл үйлдвэр чинь өөрөө дотроо 4 хэсэгтэй нь маш ойлгомжтой. 4 хэсэг байгууламжтай.

▷ Нэгдүгээрт нь, “технологийн бус туслах барилга, байгууламжууд” буюу таны саяын хэлдгээр тэр иргэний зориулалттай ийм юмнууд.

▷ Хоёрдугаарт нь, энэ “дагалдах байгууламжууд”.

▷ Гуравдугаарт нь, “цахилгаан станц”.

▷ Дөрөвдүгээрт нь, үйлдвэрийн яг үндсэн REFINERY_[нефть боловсруулах үйлдвэр], тэр технологийн лиценз шаарддаг тэр байгууламж нь гэсэн үг. Ийм 4 хэсэгтэй.

Ингээд бие биеийнхээ санхүүжилт, бие биеийнхээ гүйцэтгэлийг хүлээгээд дараагийн хэсгүүд нь хүлээгдээд байдаг ийм айхтар өндөр эрсдэлтэй. Үүнээс болж хугацаа алдаж байсан байгаа юм.

Үүнийг харин салгаад 4 хэсэг санхүүжилт, 4 фронт дээр зэрэг санхүүжилт, төлөлтүүдээ хийх боломжийг зээлийн гэрээний өөрчлөлтөөр 2023 онд хийж чадсан байгаа. Тийм.

Тэгэхээр өөрөөр хэлбэл гэрээнээс болоод дахиж ирээдүйд.../минут дуусав/

Р.Сэддорж: Б.Жавхлан сайд гүйцээж хариулъя. 3 номер.

Б.Жавхлан: Тийм. Тэгээд 2023 онд дөнгөж ЕРС-02, 03 нь эхэлсэн байгаа шүү дээ. 2023 онд.

Тийм учраас одоо цаашаагаа нэгэнт 2023 оны 09 сард батлагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр шинэ ТЭЗҮ гараад ирчхэж байгаа учраас цаад гүйцэтгэгч байгууллагад ч гэсэн эх үүсвэр нь, санхүүжилт нь аягүй ойлгомжтой байх хэрэгтэй. Нэг мөр. Тэгэхгүй хуучин ТЭЗҮ-ээр нь санхүүжүүлнэ гэхээр чинь аягүй ойлгомжгүй байдал үүснэ.

Тийм учраас аль ч төсөл дээр, зөвхөн энэ төсөл дээр ч биш бүхий л яг энэ КОВИД-ын үед энд нэрвэгдсэн энэ төслүүд дээр бүгд дээр нь яг ийм байдлууд үүссэн.

Одоо бид төсвөөр хийгдэж байгаа жижиг нэг цэцэрлэгийн барилга ч гэсэн. Бид нийт төсөвт өртөг нь нэмэгдсэн бол түүгээр нь баталж өгөөд тэр гүйцэтгэгч компани ажлыг нь хийлгэхгүйгүй бол ямар ч компанийн ийм эрсдэл хүлээгээд төслийг дуусгах ямар ч боломжгүй болно шүү дээ. Түүнтэй л адилхан юм л даа.

Тийм учраас одоо үүнийгээ.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. 3 номер Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Нэг мөр шийдэж аваад явахгүй бол ЕРС-4-д шалгарсан компани маань санхүүжилтээ хүлээгээд, гэрээгээ зурах гээд нэг жил хүлээх хоорондоо бид нарын өгсөн үнийн санал аль хэдийн 15 хувиар өсчихсөн шүү.

Одоо нэг сард гэрээгээ хийхгүй бол бид 15 хувиар өссөн байдлаар дараагийн гэрээгээ хийхээс өөр арга байхгүй. Эсвэл гэрээгээ цуцлахад бид ийм юманд хүрч байна гэдэг ийм асуудал тавиад байгаа юм. Ийм зүйлүүд байна.

Хугацааны хувьд манай компанийнхан нэмж хариулна биз.

Ер нь хэрвээ бид соёрхон батлаад 02 сарын 05-нд гэрээгээ хийчих юм бол энэ олон улсын гэрээгээрээ л бид хугацаагаа баталгаажуулахаас өөр бидэнд найдвартай баримт байхгүй болно шүү дээ. 36-аас 38 сар. Цаад тал нь 38 сар. 2025 оны 02 сарын 05-нд гэхээр 2027 оны 5 сар гэхэд ямар ч байсан ашиглалтад энэ ЕРС-04 үндсэн байгууламжаа өгнө гэж байгаа.

Р.Сэддорж: Нэмж хариулах хүн байна уу? Тодруулга. Ж.Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Ц.Туваан сайд аа, та нэг бодитой юм хэлчих тэгэх үү? Одоо яг хэдэн хувийн төсөв, одоо төсөл хэдэн хувийн үнэлгээтэй явж байна гэж.

Тэр EPC-01, 02, 03, 04 гэхээр чинь иргэд ойлгохгүй байна шүү дээ.

Тэгэхээр нийтдээ манай Монгол Улсын нефть боловсруулах үйлдвэрийн төсөл маань одоо хэдэн хувьтай явж байна гэж. Нэгт.

Хоёрдугаарт нь, би сая ярилаа шүү дээ. Эрэмбийг нь та хэд яагаад эхэлж үйлдвэр лүүгээ орж болоогүй юм бэ? Яагаад эхэлж оффисын барилгаа барьсан юм бэ гээд байна шүү дээ. Тэрийг нэг хариулаад өгөөч гэж байгаа юм.

Тэгээд ер нь дахиад цаашаа энэ чинь хугацаа сунахгүй яг хэдэнд орох вэ гэдэг асуултыг хариулаад өгчих. Ингэсээр байтал бид чинь нефть чинь бараг хэрэггүй болоод, цахилгаан, устөрөгчийн машин гараад ирнэ. Бид нефтийн үйлдвэр барих гэсээр байтал хамаг юм чинь өнгөрчих гээд байна шүү дээ.

Тэгэхээр надад бас нэг ийм хугацаа хэлээд өгөөч ээ. Энэ гурван юмыг хариулаад өгчих.

Р.Сэддорж: Ц.Туваан сайд 4 номер.

Ц.Туваан: Яг одоо бүтнээрээ хувийг нь яг тэдэн хувь гэж хэлэхэд бас жоохон хүндрэлтэй байна. Нөгөө 4 багц ажлынхаа хүрээнд л түрүүний хэлсэн хувь байгаа. Яг одоо үүнийг юу гэдэг юм энэ 4-ийг нийлүүлээд 100 хувь гэж үзвэл тэд гэж яг гаргах боломжгүй.

EPC-01-ээс 04 болгон дээрээ ийм хувиуд гарч байгаа гэдгийг хэлье.

Их Хурлаар соёрхон батлуулах зээлийн гэрээ батлагдсаны ар дээр бид гэрээгээ байгуулж эхэлснээс хойш 36-аас 38 сарын дараа үйлдвэр маань асаж ашиглалтад орно гэдэг хугацаа байгаа.

Р.Сэддорж: 5 номер нэмж хариулъя.

Д.Алтанцэцэг: Ж.Алдаржавхлан гишүүний тэр технологийн барилга байгууламжийг яагаад түрүүлж бариагүй юм бэ гэдэг.

Үйлдвэрийн 4 багц ажилд хуваасан гэдэг нь 4 зээлийн хэлэлцээрээс өөр асуудал. Тийм ээ. Инженерчлэлийн ажилд зарцуулах цаг хугацаа, байгууламжуудын төвөгшлөөс шалтгаалаад 4 хэсэгт хуваая.

Энэ эхний EPC-01 гэдэг чинь бусад ажлуудаа хийх үндэс суурь нь. Тэр баригдахгүйгээр бусад нь баригдахгүй.

Хоёрдугаарт, EPC-01-ийн ажлын зураг төсөл EPC-02, 03-ынх зэрэг явагдсан. Бүгд зэрэг явагдаад тэр инженерчлэлийн ажил нь үргэлжилж байгаа хугацаа нь л энэ.

Лицензтэй технологийн байгууламжуудын. Дандаа ерөнхий зураг төсөл ярьж байгаа шүү. Ерөнхий зураг төслийг лиценз эзэмшигчид өөрсдөө хийдэг учраас яг тэд нарын зураг төсөл эхлэхтэй нь зэрэгцээд 4-ийн сонгон шалгаруулалт явагдаж байгаа юм. Олон улсад зарласан. Аль байгууллагын, ямар компанийн патентаар барих вэ гэдэг.

Тэгэхээр түрүүлж барьж болохгүй. Тэр BASIC DESIGN гэж ярьж байгаа. Ерөнхий инженерчлэлийн зураг.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. Товч тодорхой. 5 номер.

Д.Алтанцэцэг: Иргэдэд ойлгомжтой болгохын тулд, танд бас ойлгомжтой болгоё гэж бодож байхгүй юу.

Тэр ерөнхий зураг төсөл бэлэн болохоор EPC гэрээлэгчийн тендер зарлаж байгаа юм. Тэгээд тэр тендер зарлагдсан компани өөрөө нарийвчилсан инженерийн зураг төслөө хийгээд орж ирж байгаа юм.

Тэгэхээр Б.Жавхлан сайд хэллээ. EPC-02, 03-ын гэрээ 2022 оны 10 сарын 28-нд байгуулагдсан.

Ингээд түрүүний Энэтхэгийн ЭКСИМ банктэй хэлэлцээ хагас жил үргэлжлээд тэдний хамгийн анхны тэр төлбөр нь 2023 оноос эхэлж хийж байгаа юм.

Тэгэхээр төлбөр мөнгө нь эхэлж байж тэд нар ажлаа эхэлж байгаа байхгүй юу.

04-ийнх ижилхэн. Одоо ерөнхий зураг төсөл нь дуусчихсан. Одоо компаниа бид шалгаруулаад гэрээ байгуулчихвал түүнээс 36 сарын дараа үйлдвэр ашиглалтад орно.

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: 3 удаа зээл аваад тэгээд мөнгө нь нэмэгдсээр байгаад бараг 6 их наяд төгрөг болж байгаа юм байна.

Энэ дээр чинь Хөгжлийн банкнаас гарсан 250 тэрбум, дамжуулах хоолойн мөнгө гээд бараг 7 их наяд төгрөг болж байгаа юм.

Тэгээд яах вэ мөнгөөр зодоод барьж болно л доо. 7 их наяд төгрөг ямар хэмжээний мөнгө вэ гэдгийг монголчуудад мэдэх ёстой.

Энэ бол 4 мянган километр зам буюу Монгол Улсыг Баян-Өлгийгөөс Дорнод хүртэл, хойд Алтанбулаг, Сэлэнгэ аймгаас Өмнөговь, одоо Дорноговь хүртэл авто зам барих хэмжээний мөнгө шүү дээ. Тэгээд энэ бол маш их мөнгө шүү. Ийм мөнгөөр барьж байна. 1500 сургууль, цэцэрлэг барих мөнгө.

Тэгэхээр зээлийн зарцуулалтад хяналт тавих төслийн ажлыг эрчимжүүлэх шуурхай штаб байгуулах ёстой гэдэг саналыг би дэвшүүлж байгаа юм. Тэгээд энэ дээр сайд ямар бодолтой байгаа юм.

Одоо энэ утааны асуудал, түгжрэлийн асуудалтай тэмцэх шуурхай штаб байгуулж байна. Яг үүнтэй адилхан Монголын ард түмний төлөх 7 их наяд төгрөг хэллээ шүү дээ. Монгол Улсыг баруунаас зүүн, хойноос урагш бүтэн хатуу хучилттай авто замаар холбох энэ хэмжээний мөнгийг зарцуулалтад яаж хяналт тавьж байгаа юм. Яагаад энэ төсөв нь өсөөд байгаа юм. Энэ нэг өдөр асуудал болно шүү. Би үүнийг баталгаатай хэлье.

Тийм учраас энэ дээр хуумгай хандаж болохгүй ээ.

Хоёрдугаарт нь, Монгол Улс цаашид газрын тосны үйлдвэрээ тогтвортой ажиллуулах, ашигтай ажиллуулах стратеги байна уу? Манай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд. Ямар стратеги байна. Үүнийг тайлбарлаж өгөөч.

Түүхий тосоо экспортлох нөөц Монгол Улсад байхгүй шүү. 30 сая тонны баталгаат нөөц байна гэж байна. Хэрвээ сая 500-аар бодох юм бол 20 жил энэ үйлдвэрийг чинь хангах хэмжээний нөөц. Гэхдээ энэ бүгдийг нь олборлож чадах уу, үгүй юу?

Тэгэхээр шахагддаг нөөц учраас үүнийг экспортолно гэхээс илүүтэй дотоодын үйлдвэртээ ашиглах стратегийг баримтлах ёстой. Цаашдаа. Энэ бол Монгол Улсын төр, засгийн энэ үйлдвэрээ тогтвортой ажиллуулах, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц энэ том үйлдвэрийг зөв авч явах, ард түмэндээ ээлтэй байх, өгөөжтэй байх хамгийн том бодлого.

Тэгээд энэ дээр би стратегиа гаргаач ээ гэж байгаа юм. Энэ дээр ямар зүйл барьж байна гэдгийг бас хэлье.

Тэгээд үндэсний хайгуул, олборлолтын компани байгуулах ёстой. Өөрөөр хэлбэл бид үнээгээ гаднын компаниар саалгуулж болохгүй шүү дээ. Хөрсөн доор байна. Яах вэ, одоо ингээд юуг нэмэгдүүлсэнгүй, олборлолтыг гээд асуудал бас яригдаад байх шиг байна. Яг Тавантолгойтой адилхан шүү. Тавантолгой 100 жилээр алдах гэж байсныг Монголд үлдсэн гэдэгтэй адилхан энэ чинь харин хэвлий доороо байж байгаа. Муудахгүй. Энэ хөргөгчид байгаа

өндөг биш. Энэ муудахгүй. Энэ тос нь байж байг. Үүнийг ирээдүйдээ ашиглая, үйлдвэртээ ашиглая.

Магадгүй бага экспортолж байгаа нь ашигтай ч байж магадгүй шүү. Харин ганцхан бид нарт үндэсний хайгуул олборлолтын компанийг л эрчимжүүлэх ёстой.

Өмнө яадаг байсан гэхээр Монгол мөнгөгүй учраас гаднын хөрөнгө оруулалтаар хайгуул, олборлолт хийе гэдэг л энэ концепцыг барьдаг байсан. Одоо тэгвэл энэ “Ирээдүйн өв сан”-д чинь 1.7 их наяд төгрөг байна. Үүнийг санхүүгийн хэрэгсэл болгоод ингэж.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут. М.Бадамсүрэн гишүүн 1 минут.

М.Бадамсүрэн: Хүүтэй хадгална гэхээс илүүтэй үүнийг энэ рүү оруулах ийм саналыг дэвшүүлж байгаа.

Тэгээд энэ газрын давхцал, байгаль орчин, ус бага ашиглах дэвшилтэт технологи, орон нутгийн иргэд, бичил жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, орон нутгийн хөгжлийг дэмжих гээд энэ зүйлүүдээ давхар параллель үйлдвэрээ барих 3 жилийн хугацаанд бүгдийг нь хийсэн байх ёстой. Тэгэхгүй бол энэ олборлолт чинь нэмэгдэхгүй. Энэ асуудал чинь эсэргүүцэлтэй тулгарна.

Тэгээд би энэ зөвшилцөл тогтоолд оруулах 4 санал байна. Байнгын хорооны даргад.

▶ Нэгдүгээрт нь, “төсөвт багтааж дуусга” гэдэг үүргийг өгөх хэрэгтэй. Нэмж хөрөнгө гаргахгүй.

▶ Хоёрдугаарт нь, “нэмж зээл авахгүй”. Яагаад гэвэл энэ зээлийг Монголын ард түмэн төлнө.

▶ Гуравдугаарт нь, “38 сар, 36 сардаа багтааж дуусгах” үүргийг Байнгын хорооны энэ тогтоолын төсөвт оруулж өгөөч ээ.

▶ Дөрөвт нь, “шуурхай штаб байгуулах”. Хяналт тавих гэсэн үг. Өөрөөр хэлбэл.

Эргэлзээ байгаад байгаа байхгүй юу. Энэ үйлдвэрийн баг нь чадаж байгаа юм уу, чадахгүй байгаа юм уу. Гадаад хүчин зүйл юм уу, дотоод юм уу. Яг юунаас болоод байгаа юм гэдгийг хянах хэрэгтэй.

Р.Сэддорж: Хариулт 4 номер. Ц.Туваан сайд.

Ц.Туваан: М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

Бас таны энэ асуудалд хандаж байгаа, санаа зовж байгааг ойлгож байгаа. Тэгээд яг энэ газрын тос олборлолт хийж байгаа, 90 гаруй хувийн олборлолт хийж байгаа аймгийг удирдаж байсан хүний хувиар асуудлыг анхаарч санаа зовж байгаад баярлаж байна.

Тэгээд бид хамтарч ажиллана. Энэ бол Монгол Улсын эрх ашиг учраас.

Шуурхай штабын хувьд шуурхай штаб байгуулах заавал тийм шаардлага байхгүй гэж үзэж байна.

Аж үйлдвэржилтийн байнгын хорооноос ажлын хэсэг байгуулаад Л.Мөнхбаясгалан гишүүн ахлаад ажиллаж байгаа. Бид бүхэн ярилцаад ажлын хэсэгт дүгнэлт, асуудлууд дээр нь хамтарч ажиллая гээд явж байгаа.

Засгийн газрын зүгээс Газрын тос боловсруулах үйлдвэр барих ажлыг эрчимжүүлэх ажлын хэсгийг өмнө нь ч байсан, энэ ажиллаад ирсэн. Салбарын сайдын хувиар миний бие үүнийг ахлаад 2 сар гаруй, 3 сарын хугацаа өнгөрч байна гэдгийг хэлье.

Мэдээж түрүүн би хэлсэн. 2.5 сая тонн тунгалаг нефть бүтээгдэхүүн бид импортоор авч байгаа. Үүндээ бид жил болгон 2 тэрбум ам.доллар зарцуулж байгаа. Тэгээд нэг орноос 95, 96 хувьтай импортолж байгаа учраас үүнийгээ дэлхий дээр байдаг жишиг шүү дээ. Тийм ээ. Аль болох эрсдэлгүй олон эх үүсвэрээс хангах гэдэг энэ бодлогыг бид цаашид нь бариад явна.

Энэ үйлдвэр маань ашиглалтад орсноор 4.5 их наядын жилийн борлуулалтыг хийж валютын гадагшаа чиглэх урсгалыг нэлээн хааж өгөх ийм төсөл байгаа гэдгийг хэлье.

Мэдээж энэ үйлдвэрийг ашигтай ажиллуулах техник, эдийн засгийн үндэслэл нь байгаа. Салбарын яамны хувьд мөн агентлагтайгаа хамтраад дэмжиж ажиллана. Боловсон хүчин, бусад асуудлууд дээр нь хамтарч ажиллана гэж хэлье.

Сая 6 талбай дээр бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулаад ажиллаж байгаа. Энэ дотор үндэсний компаниуд байгаа. Нэмж олборлолт хийж байгаа “Петро Матад” компани дээр гэхэд үндэсний компаниудын хувь байгаа. Нэмэгдсэн талбай болон өмнө олгогдсон талбайнууд дээр үндэсний компаниудын талбайнууд байгаа гэдгийг хэлье.

Энэ экспортын хэмжээг бид нэмэгдүүлэх гэж байгаа. Энэ бол өнөөдөр шийдвэр гараад шууд 1.5 саяыг олборлох боломж байхгүй.

Тэгэхээр бид тэр компанитай нь яриад энэ жил 750 мянган тонн хүргээч ээ. Энэ дээрээ бас хамтарч ажиллая. Ирэх жил сая ч юм уу. Ингээд жил жилээр

нэмэгдүүлж байгаад газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад ороход энэ 1.5 сая дээр нь хүргэх бодлого гаргаад ажиллаж байгаа.

Мэдээж бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр олборлосон газрын тосыг 100 хувь Монголын газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх гэрээний заалт байгаа. Энэ бол тухайн зах зээлийнх нь үнээр манай тал нөгөө талынхаа бүтээгдэхүүнд ногдож байгаа хувийг худалдаж аваад нийлүүлэлт хийх л ийм асуудал байгаа гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Б.Жавхлан сайд нэмж хариулна. 3 номер.

Б.Жавхлан: Гишүүний асуудалд нэмэлт мэдээлэл өгье.

Үнэхээр яг зардал, өртөг талаас нь харах юм бол таны хэлж байгаа үнэн. Үнэхээр яг босоо, хэвтээ дахиад бид шинэ зам барих ийм хэмжээний хөрөнгө оруулалт мөн.

Өгөөж талаас нь ярих юм бол яг тийм хэмжээний өгөөж байгаа байхгүй юу. Сая Ц.Туваан сайд хэллээ. 5.4 их наядын жилийн борлуулалт. Одоо хийх гэж байгаа хөрөнгө оруулалт маань 5.2 их наяд. Өөрөөр хэлбэл нийт хөрөнгө оруулалттайгаа тэнцэх хэмжээний борлуулалтыг нэг жил хийж чадах нь ээ.

Дээрээс нь бид доод тал нь 2 тэрбум долларын нефтийн бүтээгдэхүүн Оросын Холбооны Улсаас бараг 100 хувь авч байгаа. Үүнийхээ доор хаяж 55 хувийг буюу 1-ээс 1.5 тэрбум долларыг бид дотооддоо авч үлдэж чадах юм бол төлбөрийн тэнцлэлээр дамжаад бидэнд хамгийн том үр өгөөж ойрын хугацаанд харагдаж байгаа боломж маань ерөөсөө л энэ байгаа юм.

Тэгээд үүний төлөө л одоо бүгдээрээ зүтгэе гэж байгаа.

Тэр хугацааны хувьд болно. Хугацааны хувьд 36-аас 38 сарын дотор яг энэ гэрээнийхээ дагуу ашиглалтад орно гээд үүрэг өгч болно.

Харин нөгөө талдаа бид төсвийн энэ зарлага.../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Боломжийг нь нээж тэр тогтоолын төсөл дотроо оруулж өгөхгүй бол энэ цаг хугацаандаа яагаад ч амжих боломж байхгүй.

Одоо бид 2025 онд батлагдсан төсвийн дагуу 350 тэрбум төгрөг л гаргах боломжтой. Энэ төсөл дээр. Ингээд явах юм бол 5.2 тэрбум чинь өөрөө 15 жилийн хугацаа байхгүй юу.

Тийм учраас жилдээ 1.5-аас 1.6 их наядын зөвхөн энэ төслийн санхүүжилтийг бид төсөвтөө багтааж оруулах нь ойрын хугацааны том сорилт болчихоод байна.

Тийм учраас нэг удаагийн ийм хууль санаачилж оруулж, Их Хурал маань баталж өгч үүнийг дэмжиж явуулахгүй бол энэ төсөл дараагийн сорилт ийм байгаа.

Тэгэхээр хавар төсвийн тодотгол руу л явж таарна л даа. Одоо үүнийгээ хэрвээ соёрхон баталчих юм бол. Тэгэхгүй бол бидэнд өөр ямар ч боломж байхгүй болж ирж байгаа юм.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж нэмж минут өгье. М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Ач холбогдлыг маш сайн ойлгож байгаа. Тийм ч учраас энэ үйлдвэр ашиглалтад ороосой гэдгийг би дэмжиж байгаа.

Гэхдээ ярих нэг өөр. Үүнийг хэрэгжүүлэх стратеги байна уу л гэж би асуугаад байгаа байхгүй юу. Стратеги байна уу?

Тэгэхээр яг ийм тодорхой стратеги надад харагдахгүй байгаа байхгүй юу. Надад яг бүрхэг байгаад байна.

Тэгэхээр яг үүнийг л би асууж тодруулаад байгаа юм. Түүнээс ач холбогдлыг маш сайн мэдэж байгаа. Ер нь бид “Ирээдүйн өв сан”-гийн хөрөнгийг зөв зүйлд оруулах ёстой шүү дээ. Энэ нэгэнт л том үйлдвэр, үндэсний аюулгүй байдал бол үүнийг Монголын төр байна даа төрийн эзэмшлийн үндэсний олборлолтын компанитай болж байж түүхий эдийн тогтвортой байдлыг бид хангаж чадна. Ингэж чадахгүй бол гаднын компаниас хараат байна. Эд нар хөрөнгө оруулалтаа татаад манай үйлдвэрт түүхий эд нийлүүлэхгүй гэвэл яах вэ? 100 хувь биш шүү дээ. Бид чинь ногдох тосоо л авах эрхтэй.

Тэгэхээр энэ аягүй олон нюансууд байгаа байхгүй юу.

Тийм учраас энд би санаа зовниод байгаа юм. Энэ дээр.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт 4 номер. Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Та бүхэн, шинэ 126-тай парламент бүрдээд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж өгсөн.

Энэ хөтөлбөр дотор газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл байгаа. Мэдээж бас энэ дээр техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсан Эрдэс

баялгийн мэргэжлийн зөвлөл болон бас эдийн засгийн тооцооллын хийсэн зүйлүүд нь бүгд байгаа. Энэ бол нэлээн том дэлгэрэнгүй асуудал болно.

Бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр нь сая Газрын тосны газар, “Петро Чайна Дачин Тамсаг” хооронд хийсэн хамгийн сүүлийн протоколоор гэхэд л бид бас тодорхой болгож өгсөн. Хятадын тал Монгол Улс газрын тос боловсруулах үйлдвэртэй болсон тохиолдолд өөрт ногдох хувийг хамгийн түрүүнд эхэлж тэр Монголын талын үйлдвэрт нийлүүлнэ гэсэн ийм бүтээгдэхүүн.../минут дуусав/

Р.Сэддорж: Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Нөгөө ээлжит Дарханы замын л нэг жишээ болсон төсөл болчихоод байгаа юм л даа.

Сая бүлэг дээр нэлээн сайн мэдээлэл авлаа л даа. Тэгээд мэдээлэл авахдаа яагаад хоцроод байгаа шалтгааныг нэг бол төр засгийн буруу, Энэтхэгийн Засгийн газрын буруу, КОВИД гэсэн ийм гурван л юм ярилаа.

8 дахь жилдээ үргэлжилж байгаа төсөл шүү дээ. Тэгээд 20 хүрэхгүй хувийн гүйцэтгэлтэй. Мундаг удирдагч захиралтай ийм л мэдээлэл авлаа. Сая бол.

500 сая доллароор нэмэгдүүлнэ гэж байгаа юм. Төсөвт өртгөө. 500 сая доллар шүү дээ. Энэ бага мөнгө үү? Анхны гарсан техник, эдийн засгийн үндэслэл чинь яахаараа ийм алдаатай гардаг юм? Одоо яг хэдэн жилийн дотор өөрийнхөө өртгийг нөхөх вэ? Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал. Яагаад Дорнод руу ер нь тэр хийн хоолой татсан юм? Яагаад төмөр зам татаагүй юм?

Хоёрдугаар асуудал. 15-хан жилийн л нөөцтэй юм байна шүү дээ.

Та нар тэгсэн бол тийшээ нэг төмөр зам юм уу, эсвэл авто замаар шийдсэн бол ядаж дараад нь тэр нөөц чинь дуусчихвал бид дараа дараагийн юманд ашиглана гэж бодох байсан л даа. Яагаад баахан ажилчдын орон сууц барьсан юм? Энэ Ж.Алдаржавхлан асуугаад байгаа үнэн шүү дээ.

Тэгээд өнөөдрийг хүртэл миний санаж байгаагаар хоёр дахь удаагаа хойшилж байна. Хугацаа нь. Одоо дахиад хойшлуулна гээд. 38 сарын хугацааны асуудал ярьж л байгаа юм байна л даа.

Тэгээд өнөөдрийг хүртэл хойшилсон хугацаан дээр хэн яг ямар хариуцлага хүлээсэн бэ? Салбар дундаа хаягдаад л, хариуцсан эзэн нь мундаг удирдагчдаа мөртлөө төсөл нь дундаа ч ордоггүй, явдаг ч үгүй. Одоо асуудал нь юу вэ гэхээр бид энэ зээлийн гэрээг өнөөдөр зөвшөөрлөө гэж бодоход төсвийн тодотгол хийх асуудал яригдах нь байна шүү дээ.

Тэгээд үүнийг төсвийг ярьж байх үед хэн ч ганц ч үг дуугарсангүй. Төсвийг баталж байхад хэдэн попорсон гишүүдэд хэлж л байсан шүү дээ. Төсөв алдагдалтай болж байгаа шалтгаан нь энэ том төслүүд байгуулахаар алдагдалтай баталж байгаа юм гээд. Тэгсэн мөртлөө Засгийн газрын гишүүдээс хэн ч тэнд байр сууриа илэрхийлээгүй.

Тэгээд уг нь энэ төсөл дээр мэргэжлийн хүн биш. Энэ дээр уг нь улс төрч, BACKGROUND-тай хүн байх ёстой байсан байхгүй юу. Яах вэ, мэргэжлийн хувьд сайн, мундаг л хүн захирал хүн байх л даа.

Энэ чинь яг энэ асуудлуудыг яриад яваад ойлгуулдаг, тэр Засгийн газрын буруу гэж байгаа бол Засгийн газар асуудлаа ярьж ойлгуулдаг, гишүүдтэй ирж тулж ажилладаг, Энэтхэг рүү очиж уулздаг ийм л хүн байх хэрэгтэй шүү дээ. Наадах чинь дунд чинь хаягдчихаад байна шүү дээ. Ажил нь.

Ер нь 8 жил гэдэг маань одоо яг мега төсөл дээр ямар хугацаа юм? Яагаад байн байн алдаатай хугацаа чинь орж ирдэг юм?

Р.Сэддорж: Хариулт 3 номер. Сангийн сайд.

Б.Жавхлан: Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Тийм ээ. Төсөв яг хэлэлцэж байх үед энэ асуудал огт яригдаагүй. Нэмэлт санхүүжилт нь. Яагаад вэ гэхээр Энэтхэгийн талаас бид ерөөсөө огт хариу ирээгүй. Маш тодорхойгүй байсан. Хэлэлцээр үргэлжилж байсан.

Ингээд Энэтхэгийн талаас эцсийн байдлаар 12 сарын 09-нд бидэнд цахимаар мэдэгдсэн байгаа. Баталгаажаад албан ёсоор цаасаар дипломат шугамаар 12 сарын 22-нд ирсэн байдаг юм. Үүнээс хойш энэ асуудлууд шат дараатай явж байгаа юм.

Ер нь яах вэ алдагдалтай төсөв, алдагдалгүй төсвийн хувьд шууд тийм маневр хийж байгаа тохиолдолд нэгэнт тогтчихсон Засгийн газрын үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа урсгал зардал түрүүлж орох ямар ч боломжгүй байдаг. Хойшлуулж болох бодлогын орон зай нь яг энэ хөрөнгө оруулалттай л холбоотой ийм бодлого шийдэл бидэнд сонголт үлддэг байгаа.

Одоо нэгэнт бид ийм горим руу орсон учраас цаашдаа энэ томоохон төслүүдийн хувьд эрэмбэлээд, ялангуяа одоо яг өөрийн эх үүсвэртэй бусад урсгал зардлуудтай харьцуулах юм бол энэ маань өөрөө энэ чинь долларын эх үүсвэртэй. Төлбөрийн тэнцэл дээр харьцангуй бага дарамттай ирдэг учраас эдгээр төслүүдийг зардлын хязгаарт нэг удаа оруулахгүй байх ийм тусгай дүрэм гаргаж энэ төслүүдээ яаралтай 3-аас 4 жилийн хугацаатай нэг удаагийн хуулиар бид зохицуулалт хийхээс өөр аргагүй болно.

Тийм учраас хаврын чуулган эхэлмэгц хэрвээ энэ төсөл маань санхүүжилт нь соёрхон батлагдах юм болбол тодотгол хийж, ийм зохицуулалтыг хийх санал оруулна.

Р.Сэддорж: Ц.Туваан сайд гүйцээж хариулъя.

Ц.Туваан: Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

“Газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит компанийн удирдаж байгаа Д.Алтанцэцэг захирал дээр би бас өмнө нь Улсын Их Хурлын гишүүн байхдаа яагаад уддаг, яагаад урагшлахгүй байна гээд асуудлуудад нэлээн сөрөг ханддаг байсан. Яг үнэнийг хэлэхэд.

Тэгээд яг энэ салбарт ирээд үйл ажиллагаатай нь танилцаад юмнуудыг нь ухах төнхөөд ингээд үзэхээр бас яг удирдагчийн зүгээс, төслийн удирдагчийн зүгээс бүхий л нөөц бололцоо, бүхий л байдлаа дайчилж, ялангуяа саяын таны хэлсэн асуудлуудыг нэлээн өдөр, шөнөгүй хөөцөлдөж ажиллаж байгаа.

Тэгэхээр Д.Алтанцэцэг захирал дээр хэлэх сөрөг комент алга гэдгийг хэлье.

Хоёрдугаарт, түүхий тосыг тээвэрлэх асуудал байгаа. Энэ бол хоёр шалтгаантай.

Нэгдүгээрт, түүхий тосыг дэлхийн практикт хоолойгоос өөр дамжуулалтаар тээвэрлэдэггүй.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. 4 номер.

Ц.Туваан: Тээвэрлэдэггүй. Далайд гарцтай улсуудын хувьд далайн тээврийг ашигладаг. Тэгээд өртгийн хувьд төмөр замаас гэхэд 5 дахин бага өртгөөр энэ хоолойгоор дамжуулах нь бага байгаа.

Тэгэхээр энэ зүйл 2020 онд шийдвэр нь гараад, тендер зарлаад, гэрээ байгуулаад явж байгаа.

Р.Сэддорж: Х.Ганхуяг гишүүн тодруулж асууна.

Х.Ганхуяг: Тэгэхээр түрүүний ярьж байснаар өнөөдрийг хүртэл төсөл явахгүй байгаа шалтгаан төр, засгийн буруу гэж би ойлголоо. Зөв үү? Энэ тодруулгаа авчихъя.

Хоёрдугаарт, яагаад би үүнийг асуугаад байна гэхээр 38 сарын дараа энэ төсөл ашиглалтад орохгүй бол улс төрийн хариуцлага хэн хүлээх юм? Үүнийг бас хариугаа авчихмаар байна.

Гуравдугаарт, ТЭЗҮ-ээр одоо яг хэдэн жилийн дотор наад төсөл чинь өөрийгөө ер нь нөхөхөөр байгаа юм. Энэ гурван асуулт дээр яг тодорхой хариу авмаар байна.

Р.Сэддорж: Хариулт 4 номер. Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Х.Ганхуяг гишүүний асуултад нэмж хариулъя.

Энэ “Газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит компанийн удирдлагыг “Эрдэнэс Монгол” нэгдлийн дотор ордог. “Эрдэнэс Монгол” нэгдлийг өнөөдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хяналтдаа буюу энэ компанийн хувьцаа эзэмшигч нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байгаа гэдгийг хэлье.

Яах вэ мэдээж том төсөл дээр маш олон зүйлээс шалтгаалдаг. Гадаад, дотоод маш олон зүйлүүд байгаа. Энэ төслүүд удааширсан дээр.

Тэгэхээр бид одоо бас л саяын энэ нэмэлт зээлийн санхүүжилтийг хүсээд жил 6 сарын дараа л зөвшөөрсөн хариу авч байх жишээтэй. Гэх мэтчилэн ийм хүндрэлүүд бас байгаа гэдгийг хэлье.

36-аас 38 сарын дараа ашиглалтад оруулахын төлөө ажиллана. Энэ дээрээ бид нэлээн тооцоо судалгаатай ажиллаж байгаа.

Тэгээд хариуцлагыг бол ажлын хэсгийн ахлагчийн хувиар хариуцлага хүлээх шаардлага үүсвэл хариуцлага хүлээнэ.

Р.Сэддорж: Х.Ганхуяг гишүүн. Хариулт хангалтгүй гэж үзэж тодруулж асууя.

Х.Ганхуяг: Би техник, эдийн засгийн үндэслэл дээрээ хариугаа авчихмаар байна. Хэдэн жилийн дараа наад өртгөө нь өгөх юм?

Яг протокол дээр яг хэн хариуцлага хүлээх вэ гэдгээ та надад протоколд үгээ хэлээд үлдээмээр байна.

Р.Сэддорж: 4 номер. Ц.Туваан сайд.

Ц.Туваан: ТЭЗҮ-ээрээ бол 7-гоос 7.5 жилийн дотор анхны оруулсан хөрөнгө оруулалтаа нөхнө гэдэг ийм тооцоолол байгаа. Тийм. Эхний гарснаараа. Тийм.

Хоёрдугаарт, хариуцлага дээр би сая хэлчихлээ. Энэ дээр мэдээж Засгийн газар л хариуцлага хүлээнэ гэж хэлье дээ. Одоо өөр юу гэх вэ. Ер нь хувьцаа эзэмшигч нь.

Бас манай яаманд байсан л юм билээ. Тэгээд одоо бол бусад зардал чирэгдэлтэй холбоотойгоор ингээд “Эрдэнэс Монгол”-ын хүрээнд, тэгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр байгаа.

Ажлыг нь эрчимжүүлэх ажлын хэсгийг би ахалж байгаа.

Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр мөн ажил эрчимжүүлэх, дүгнэлт гаргах ажлын хэсэг томилогдоод Л.Мөнхбаясгалан гишүүн ахлаад явж байгаа.

Р.Сэддорж: Нэг асуулт. Бүтээгдэхүүн хуваах гэрээг ер нь хэд хэдэн хувиар хийсэн юм бэ? Тэгээд хэдэн хувь нь экспорт, тэгээд хэдэн хувь нь үйлдвэр лүү.

Дараагийн асуулт бол энэ нефтийн хоолойн төлбөрт хэдэн сая тонн бүтээгдэхүүнээрээ явж байгаа юу? Эсвэл тонноороо явж байгаа юу, эсвэл доллар үнээрээ явж байгаа юу? Ийм асуулт байна.

Дахиад нэмэлт нэг жижигхэн асуулт байна. Метр квадрат барилгын үнэ ер нь хэдтэй байна вэ? Энэ төслийн барилгууд дээр. Дорноговь аймаг бол барилгын материал хамгийн хямдтай ийм газар байх ёстой. Замын-Үүд боомтын хажууд. Энэ дээр ийм 3 асуулт байна.

4 номер Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Хоолойтой холбоотой асуудлыг нь би. Метр квадратын үнэтэй холбоотой асуудлыг Д.Алтанцэцэг захирал. Бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьтай холбоотой асуудлыг Ч.Хишигдалай нар хариулна.

Хоолойн дээр өнөөдөр тендер зарлаад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “NORINCO” компани 380.0 сая долларын үнээр тендерт шалгараад өнөөдөр 82 хувийн гүйцэтгэлтэй явж байна. Энэ 380.0 сая доллартоо өнөөдрийн байдлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 4 компани “Эрдэнэс Тавантолгой” компаниас урт хугацаанд нүүрс авч байгаа.

Тэгэхээр үүний төлбөр нь нүүрсээр төлөгдөж байгаа гэж хариулъя.

Р.Сэддорж: 5 номер.

Д.Алтанцэцэг: Үйлдвэрийн иргэний барилга, байгууламжийн хувьд 1 метр квадрат барилга ойролцоогоор 1 сая төгрөгөөр баригдсан.

Р.Сэддорж: 5 номер.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай.

Яг өнөөдөр Монгол Улсад ашиглалтын 4 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ хэрэгжиж байна.

“Петро Чайна Дачин Тамсаг” компанийн хэрэгжүүлж буй бүтээгдэхүүн хуваах 2 талбай. Нэг талбай дээр нь 27.5 хувь, нөгөө XXI талбай дээр 24 хувь Монгол Улсын Засгийн газарт ногдож байгаа.

“Доншин” бүтээгдэхүүн хуваах гэрээ ХСVII талбай дээр нийт 28.5 хувь нь Монгол Улсын Засгийн газарт ногдож байгаа.

Р.Сэддорж: Тэгээд үүгээрээ л хангана гэсэн үг. Тийм ээ.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Б.Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. М.Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Р.Батболд гишүүн.

Р.Батболд: Уг нь мөнгө төгрөгтэй холбоотой асуудлыг нэг их айхтар ярихгүйгээр орхичихъё гэсэн чинь гишүүд яриад эхэллээ.

Тэгэхээр ийм юм байгаад байгаа юм. Энэ 1 тэрбум доллароо бид аваад хэрэглээд байгаа юм байна. Тэгээд EPC-01 нь бол дууссан юм байна. Цаана нь 599.0 сая долларын EPC-02, 200 хэдэн сая долларын EPC-03 гэдэг төслүүд нь үлдчихээд байгаа.

Одоо бид нарт EPC-04-ийг барихад 464 хэрэгтэй гэсэн чинь үгүй юм шиг байна. Тэр чинь хуваагдаад EPC-02, 03 дээрээ орох юм байна гэж ойлголоо.

Тэгэхээр одоо нэг асуудал байгаад байгаа юм. Би EPC-04-ийг чинь уг нь үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж, барилга гэж ойлгосон чинь EPC-02 нь болж таараад байх шиг байна. Тийм үү.

Тэгэхээр би зүгээр Д.Алтанцэцэг даргад тэгээд хэлчихмээр байна. Энэ дараагийн Байнгын хорооны хурал дээр зүгээр нэг товчхон. EPC-01, 02 чинь ийм ийм барилгууд байсан юм. Зүгээр жагсаалтаараа. Тийм ээ.

Тэгээд одоо гүйцэтгэл нь ийм байгаа юм шүү гэдгийг зүгээр нэг зураг хөрөгтэй нь. Нэг ийм байдалтай байгаад байна. Бид нарын 20 хувийн гүйцэтгэл гээд яриад байна шүү дээ. 13 хувийн гүйцэтгэл гээд л яриад байна. Үүнийг зүгээр нэг зураг хөрөгтэй нь. Одоо ийм байдалтай байгаа болоод ингэчихсэн юм. Тэдэн төгрөг зарчхаад байгаа юм шүү гэдгийг нь гаргаад ирээч ээ гэж хэлэх гээд байгаа юм. Тийм ээ. Одоо 599-өөсөө бид хэдийг нь зарчхаад 20 хувийн гүйцэтгэл чинь одоо ямархуу байдалтай юу харагдаад байгаа юм, ямар юм болох ёстой юм гэдгийг нь нэг харьцуулаад харуулчих л юм. Товчхон. Тийм ээ. Аймаар урт юм хэрэггүй шүү дээ.

Тэгэхээр нэг ийм тайлбарыг Эдийн засгийн байнгын хороон дээр тайланг нь сонсчихмоор байх юм. Дарга. Хэзээ байж болох вэ. Яаж болох вэ. Тийм. Мэдээлэл сонсоод явчихмаар байна. Тийм. Нөгөөдөр гэхэд амжуулаад.

Р.Сэддорж: Гурав дахь өдрийн хурал дээр мэдээлээ сонсчихъё. Тийм ээ.

Р.Батболд: Уг нь асуугаад бараг хариулт авчихмаар нэг юм байгаа юм. Тэр нь ЕРС-03-тай холбоотой юм л яримаар байгаад байна л даа. Энэ чинь 35 мегаваттын станц юм байна шүү дээ. Цахилгаан станц.

Сая бид ашиглалтад оруулдаг Дорнодын дулааны цахилгаан станц чинь 50 биз дээ. 50 шүү дээ. Тэгээд 100 саяын хөрөнгө оруулалт биз дээ. Одоо бид 160-ыг тавьчихсан байгаа мөртлөө яагаад хүрэхээ байчхаад нэмнэ гэж яриад байгаа юм. 160-аар 35-ыг барих гээд байна шүү дээ.

Дорнодод бид 50-ийг 100-гаар барьчихсан мөртлөө одоо 160 чинь яагаад хүрэхгүй байгаа юм. Тийм. Гаднынх нь 80, Монголынх нь 25 шүү дээ.

Одоо энэ яагаад хүрэхээ байчхаад байгаа юм. Энэ дээр дахиад яагаад нэмнэ гэж яриад байгаа юм. Тэгээд энэ чинь хүчин чадал нь бүр бага юм байна шүү дээ. Тийм. Би уг нь ярихгүй. Дараа нь тодруулаад өөр юман дээр явъя гэсэн чинь гишүүд яриад эхэлж байгаа болохоор үүнийг сонсчихмоор санагдаад явчихлаа л даа.

Р.Сэддорж: Гурав дахь өдөр дэлгэрэнгүй. Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр.

Р.Батболд: Үүнийг оруулж ирээд сонсмоор байна. Тэгэх үү? Тийм.

Р.Сэддорж: Гурав дахь өдрийн хурал дээр Уул уурхайн сайд үүнийг дэлгэрэнгүй хариулт хийх нь ээ. Уул уурхайн яам.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Засгийн газраас энэ зөвшилцөх асуудал оруулж ирлээ.

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын 4 дүгээр багц болон магадалшгүй бусад ажил шаардагдах зардлыг санхүүжүүлэх зорилгоор холбогдох хэлэлцээрийг оруулж ирж байна.

Тэгэхээр энэ төсөл нэгэнт гараанаасаа гарчихсан учраас одоо бид хэд аль болохоор Монгол талаасаа яг хариуцлагатайгаар юу хийж болох вэ, тэр төлөвлөгөө, цаг хугацаа, ажлын дэс дараалал, түүнд хариуцах эзнийг нь их тодорхой болгосоор байна гэдэг зүйлийг л би энэ ташрамд хэлэх гээд байна.

Сая Хассуурийн Ганхуяг гишүүний хэлж байгаа зөв шүү дээ. Бүгд л одоо яах вэ, төсөв дээр асуудлыг яг ойлгоогүй. Одоо ингээд нөгөө ярьж байсан төсөв бол хавар тодотгох нь ойлгомжтой болж байгаа юм байна. Баахан хүмүүс хуйларан шуугиулаад л Монголд зарчим тогтоолоо л гэсэн.

Тэгээд эцсийн дүндээ би ч гэсэн бас энэ асуудлыг нь ойлгоод төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийг хойшлуулж байгаад ч хамаагүй том төслүүдийнхээ юмнуудыг нэг жоохон явуулаач ээ л гэдэг зарчим. Өөрөө бас энэ төрийн албан хаагчаас гарч ирсэн мөртлөө л сэтгэл зовоод хэлж байгаа юм.

Сая Б.Жавхлан сайдын хариулт нь байна шүү дээ. Энэ хэлэлцээр удах тусам бараа, материалын үнийн өсөлт, ажиллах хүчний зардлууд ёстой Монгол Улсыг энэ төсвийн алдагдлаас нь илүү том том алдагдлуудыг цаашид нь үүрүүлэх байхгүй юу. Тэгээд энэ угаасаа одоо зогсох боломжгүй болчихсон.

Тэгэхээр бид хэд ямар цаг хугацаа, дэс дараалалтайгаар маш хурдан төслийн менежментийг хийх вэ гэдгээ Засгийн газар дээр бодолцооч ээ.

Ц.Туваан сайдын хариулт дээр сая эзэн биегүй байж байгаа юм байна. Одоо ерөнхийдөө маш олон байгууллагуудыг хариуцуулж, яг энд тэнд тэг ингэ гэдэг ийм байгууллагуудад яг ингэж хариуцлагын асуудал нь үлддэг. Хэн хариуцах нь сүүлд нь байхгүй. Яг үүнийг сүүлдээ эцсийн дүндээ “Эрдэнэс Монгол”-ын Н.Наранцогт захирлаас хариуцах юм уу. Би гүйцэтгэх түвшинд яримааргүй байна. Эсвэл Н.Учрал сайд хариуцах юм уу, Ц.Туваан сайд хариуцах юм уу. Мэдэгдэхээ байчхаж байгаа байхгүй юу.

Эзэнжүүлээд хариуцуулбал яг хариуцсан шиг хариуцуулмаар байна. Ингэж яваад байхаар ерөөсөө сүүлдээ энэ шийдвэр гаргах процесс чинь эргэлдэж гурван сайдыг ойлгуулж байж жишээ нь захирал дээшээ гарч ирэх гэж юм болж байгаа юм.

Хэд хэд нь бол уурхайн компаниудыг бас хэт төвлөрүүлж менежмент хийнэ гэдгийн алдаа энэ. Бас сектор сектор нь хослуулах асуудал. Энэ зүйлүүдээ бодохгүй бол “Эрдэнэс Монгол”-ыг давж гарч ирнэ. Дараа нь Хэрэг эрхлэх газар дээр учраа олно. Яг ийм юм би зүгээр бодитой Засгийн газрын түвшинд мэргэжилтнээс эхлээд ажиллаж байсны хувьд хэлье.

Тэгээд сүүлд нь асуудал гараад ирэхээр эзэн биегүй ийм юм болдог. Тэгээд дандаа энэ үнэ төлбөрийг нь татвар төлөгчдийн бололцоо буюу эргээд л бид нарын төлөх зээл маань ихсэж байна л гэсэн үг.

Магадгүй дахиад зээл гэдэг юм уу, хөрөнгө дутагдахыг бас үгүйсгэхгүй л байна. Энэ хурдаараа явбал.

Тэгээд би өөрөө энэ төслийг анхнаас нь дэмжиж Хууль зүй, дотоод хэргийн яаманд ажиллаж байхдаа Газрын тосны үйлдвэрийг дэмжих хуулийн төслийг нь яг энэ төсөлд зориулсан хуулийг нь хүртэл бичилцээд гүйж байсан хүн байхгүй юу. Тэгээд одоо харамсалтай байна.

Тэгээд одоо ингээд орж ирэхээрээ нөгөө еэвэнгийн үлгэрээр яриад байгаа байхгүй юу. Тэгж байгаа. Би эрчимжүүлэх ажлыг нь хариуцаж байгаа. Ц.Туваан сайд сайн байна, Б.Жавхлан сайд сайн байна.

Тэгэхдээ энэ зүйлүүдээ хэдүүлээ төсвийг хэлэлцэхдээ хүртэл зарчмаар нь ярихгүй бол ингэж парламент, Засгийн газар хоёр бие биеэ нэг аргалдаг. Ямар ч байсан тухайн үе улс төрийн нюанс дээрээ тааруулж явчхаад одоо араас нь орж ирээд төсөв дөнгөж хэрэгжиж эхэлж байгаа дээр харж байна уу. 01 сарын арван хэдэн байна. 13-ны өдөр дээр шинэ төсөв хэрэгжээд эхлээд тодотгол хийнэ гэдэг зүйлийг хэлж байгаа биз.

Үүнийг шударгаар хэлж байсан гишүүдийг бараг л хулгайчаар нь дуудсан шүү дээ. Ийм л байна.

Тэгээд одоо яг л ийм нөхцөл байдал дээр хэдүүлээ ийм жүжиг тавьж хоёрын хооронд ингэж хүмүүст таалагдах гэж.../минут дуусав/

Р.Сэддорж: Баатаржавын Мөнхсоёл гишүүн үг хэлнэ.

Б.Мөнхсоёл: Энэ төсөвтэй холбоотой хэсэг дээр санаа зовоод.

Б.Жавхлан сайд хэллээ. Нэг л дүрэм өөрчлөх хэрэгтэй байгаа юм. Яагаад гэвэл алдагдалгүй төсөв гэдэг дээр Засгийн газрын өрийн дээд хэмжээ, таазаа зөрчих учраас дүрмээ нэгхэн удаа, ганц удаа энд зориулаад өөрчилье гэсэн үү. Тийм.

Ямар ч байсан сая П.Сайнзориг гишүүний хэлсэн шиг юм болох нь. Тэр эргээд итгэлцэл бага байгаа энэ үед дахиад л нэг эмзэг байдал үүсгэх магадлалтай л юм байна гэж харлаа.

Тэр ямар ч байсан нэг дүрэм гаргана гэдэг чинь өөрөө эргээд. Сая П.Сайнзориг гишүүний хэлж байгаатай холбогдуулаад. Тийм.

Хоёрдугаарт нь, зээлийн хэлэлцээр, гэрээг харахаар 7.1-д авсан зээлээ ашиглаагүй тохиолдолд. 7.3 дээр хэлж байна шүү дээ. Зээлийн ашиглалт хийгдээгүй ч гэсэн зохих ёсны тохиролцсон зээлийн хүүгээ төлнө гээд. Тийм ээ. Алдагдал байвал бас төлнө гээд. 8 дугаар хэсэг дээр бас дефолтын үед юу хүлээх вэ, манай тал ямар хариуцлага хүлээх вэ гэдгийг биччихсэн байна.

Тэгэхээр энэ хэсгүүдээ сайн анхаарахгүй бол 2019 онд байгуулсан гэрээгээр 236 сая доллар босгосон мөртлөө ашиглаагүй. Одоо энэ гэрээ

хэлэлцээрээр тэрийг хаачих юм байна шүү дээ. Одоо энэ байгуулж байгаа хэсэг дээр хүү төлөх хариуцлагаа сайн харах ёстой юм байна шүү л гэж бодож байна.

Тэгэхгүй бол бусад гишүүдийн хэлээд байгаачлан хариуцлагын асуудал хөндөгдөх нь л гэж хэлмээр байгаа юм.

Р.Сэддорж: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн үг хэлнэ.

М.Бадамсүрэн: Тэгээд шалтаг тоочвол одоо тэгээд л мундахгүй л дээ.

Дорнодын 50 мегаваттын дулааны цахилгаан станц яг адилхан КОВИД, үнийн өсөлтийн цаг үед баригдсан. Сүүлийн жилүүдэд баригдсан ганц л станц.

Бид орон нутгаас бүх талаар дэмжиж тусалж ажиллаж байсан. Ер нь болдог л юм билээ.

Тийм учраас энэ зүйл дээр янз бүрийн шалтаг битгий тоочооч ээ. Монголын ард түмэн үүнээс цааш хүлээж тэвчихгүй шүү гэдгийг л би хариултаар хэлье гэж бодож байгаа юм.

Тэгээд хэрэгжилтийг нь жил бүрийн эцэст нь дүгнэмээр байна. Төсөв хэлэлцэх үеэр. Өөрөөр хэлбэл 3 жилийн хугацаанд баригдаж дуусна гэж байгаа бол нийт ажлынхаа объёмыг 3 хуваадаг юм уу, тэгээд 2025 оны жилийн эцэст 2026 оны төсөв батлах цаг үед нь яг хэдэн хувийг нь гүйцэтгэлээ, төлөвлөгөөгөө хийж чадсан юм уу гэдгийг дүгнэж. Үүнийгээ биелүүлж чадаагүй бол заавал 3 жил хүлээхгүйгээр хариуцлага тооцоод явъя.

Ц.Туваан сайд аа, би инээдэм яриагүй шүү. Үгүй үгүй. Яагаад саналаа хэлж байгаа юм. Танд инээдэмтэй байж болно. Бидэнд ханиадам байна. Үгүй нээрээ бидэнд ханиадам байна шүү. Аан. Үгүй нээрээ тоглоод байгаа бол тэрийгээ хэл.

Үгүй үгүй, тэгээд яагаад байгаа юм бэ. Би саналаа хэлж байна шүү дээ. Тийм. Би харин саналаа хэлж байна шүү дээ. Хэрэгтэй саналаа хэлж байна шүү дээ. Өөрийнхөө цаг дээр.

Хэрэгжлийг нь жил бүр дүгнэх ёстой. Тэгээд тэр хуваариар нь хариуцлагын асуудал ярих ёстой. Тэгэхгүй бол тэгээд л зээлээ нэмж л байдаг. Тэгээд л хугацаа нь явж л байдаг. Янз бүрийн шалтаг КОВИД гээд нөгөө “муу бол зүүн хойд хар овоохой” гэдэг шиг өнгөрсөн, баларсан, улирсан КОВИД руу, үнийн өсөлт рүү бүх юмаа чихэж болохгүй байхгүй юу. Тийм учраас үүнийгээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд саналаа хүргүүлбэ гэж бодож байна. Би яг түрүүнийхээ саналыг. Одоо зээлийн хэмжээг дахиад нэмэгдүүлэхгүй. Угаасаа Энэтхэгийн Засгийн газар нэмэгдүүлэхгүй гэдэг саналаа хэлчихсэн юм байна шүү дээ. Болзлоо. Нэмэгдүүлэхгүй.

Хоёрдугаарт нь, хугацаандаа ашиглалтад оруулна. Ингэж хатуу болзол тавьж өгөхгүй бол ингээд л нэг өнгөрөөсөн байдалтай ингээд яваад байх юм бол 3 жилийн дараа дахиад үүнийгээ яриад сууж байхад бид байг гэхгүй ийм газар болчихоод байгаа байхгүй юу.

Тийм учраас үүнийгээ яая аа. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, би дахин давтаад хэлье. Нөөцөө бүрдүүлэх, түүхий эдийнхээ нөөцийг бүрдүүлэх ажлаа үйлдвэр барих, үүнтэйгээ зэрэгцүүлж бид бодож тооцож, стратеги гаргаж хэрэгжүүлж явахгүй бол энэ ажил чинь асуудал үүснэ шүү. Нэг мэдэхэд л 3 жил өнгөрнө. Нэг мэдэхэд өнгөрнө.

Тэгээд тэр үед нь “хонх нь дуугарахаар дамар нь таг, хоёулаа дуугарахаар лам нь таг” гэдэг шиг үйлдвэр нь ч баригдаагүй, эсвэл нөөц нь ч байхгүй. Тэгээд энэ үйлдвэр чинь хамгийн осолтой нь өндөр технологийн үйлдвэр гэж байгаа юм. Сая 500-г үйлдвэрлэхгүй, сая юм уу, сая 200, сая 300-г үйлдвэрлэвэл шууд алдагдалд орно. Юун эдийн засгийн үр ашиг.

Тийм учраас энэ өөрөө аягүй том асуудал учраас энэ зүйл дээр бид санаа зовоод байгаа юм. Санаа зовоод байгаа юм. Байнгын хорооны гишүүний хувьд, Их хурлын гишүүний хувьд зүгээр байгаад байж чадахгүй байгаа байхгүй юу. Энд ингээд бачимдаад байна шүү дээ. Яах бол. Энэ маань орохгүй болчих болов уу, үр ашиггүй болчих болов уу, нөөц нь яах бол. Энэ чинь бас хариуцлага үүрдэг юм байна шүү дээ. Их Хурлын гишүүн гэдэг чинь бас ард түмний өмнөөс сонгогдсон болохоор.

Тийм учраас энэ зүйл дээрээ анхаараарай гэдгийг албан ёсоор хэлье.

Тэгээд Байнгын хорооны дарга саяын тэр үнэ, хэмжээ хязгаартай холбоотой Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд саналаа хүргүүлж болох уу? Байнгын хорооны санал болгож хүргүүлж болох уу? Гишүүдийн зүгээс ийм санал гаргаж байна. Тэгээд дэгийн дагуу шийдэж өгөөч.

Р.Сэддорж: Гишүүдийн гаргасан саналуудыг тусгаж Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд оруулна.

Ингээд гишүүдийн сая гаргасан санал, асуулт хариултуудыг Та бүхэн маань ажилдаа сайн тусгаж ажиллахгүй бол түүхэнд том юунд ч орж мэднэ шүү дээ.

Тийм учраас хариуцаж байгаа хүмүүс маш хариуцлагатай. Төрийн зүгээс хариуцаж байгаа хүмүүс танай байгууллагыг сайн мэдэхгүй шүү дээ. Төрөөс тэр газрын тосны хэрэгжүүлж байгаа ажлуудыг чинь.

Аймаг, орон нутагтайгаа ер нь хэр холбогдож байгаа вэ. Аймаг, орон нутгаасаа дэмжлэг авч байгаа юу. Хоёр бүсийн асуудал байна. Зүүн бүсээс бүтээгдэхүүн гараад говийн бүсэд хэрэгжих тийм төсөл байгаа юм байна. Энэ төсөл.

Тэгэхээр аймаг, орон нутгийн хоёр бүсээс сонгогдсон гишүүд эд нарынхаа дэмжлэгийг ер нь авч байгаа юу. Говийн бүсээс 7 гишүүн байна. Зүүн бүсээс 7, 8 гишүүн байна.

Тэгэхээр дэмжлэг, харилцан уялдаа юмнуудаа сайн бодож ажил хэрэгтээ хэрэгжүүлээрэй гэдгийг захиж хэлье.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо санал хураалт явуулна.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд бэлэн байгаарай.

Ингээд зөвшилцөхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Алдаржавхлан гишүүнийг дэмжсэнээр бүртгэлд авъя.

Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах Зээлийн хэлэлцээрийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл танилцуулна.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хоёр.Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.01.02-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

Дараагийн асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал хоёр.

Монгол Улсын Улс болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя.

Зээлийн хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Сайдын микрофоныг нээе. 4 номер. Сайдын микрофон.

Б.Жавхлан: Баярлалаа. Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

“Эрчим хүч 3” буюу Багануур, Чойр чиглэлийн 188 километр 220 киловаттын хоёр хэлхээд цахилгаан дамжуулах агаарын шугам дэд станцын өргөтгөх төсөл нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого болон Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрчим хүчний өндөр ач холбогдолтой төсөл билээ.

Засгийн газрын зүгээс тус төслийн зээлийн хэлэлцээрийг Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт хөгжлийн банктай 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хийж, Засгийн газрын 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдлээ.

Төслийг Дэлхийн банкны 47 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бөгөөд тус зээл нь SOFR /Secured Overnight Financing Rate/ буюу баталгаат овернайт санхүүжилтийн 1.44 хувийн нэмэгдэлтэй хувьсах хүүтэй. 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөөд, 25 жилийн хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй.

Зээлийн хөрөнгийг Өрийн удирдлагын тухай хуулийн 24.3-д заасны дагуу эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит хувьцаат компанид дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөсөн болно.

Төслийг хэрэгжүүлснээр Багануур, Чойр чиглэлийн 110 киловаттын цахилгаан дамжуулах агаарын шугамын дамжуулах чадварыг хоёр дахин нэмэгдүүлж, Багануур, Чойр дэд станцуудыг өргөтгөн, эрчим хүчний чанар, найдвартай ажиллагаа, тогтвортой байдал хангагдахаас гадна өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа зүүн бүс нутгийн эрчим хүчний хэрэглээг саадгүй хангах боломжийг бүрдүүлнэ.

Өөрөөр хэлбэл үзүүрээс нь цаашаага задарч түгээх өргөн боломж нээгдэнэ гэсэн үг.

Иймд Монгол Улс Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд “Эрчим хүч-3 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Сайдад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Л.Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, О.Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүүгийн хөрөнгө оруулалтын газрын дарга, Г.Энхтүвшин Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Дашдаваа Эрчим хүчний яамны “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн захирал.

Б.Чойжилсүрэн сайд яасан?

Ингээд зээлийн хэлэлцээрийн төслийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Асуулттай гишүүд байна уу? Л.Соронзонболд гишүүн. Л.Соронзонболд гишүүнээр тасаллаа.

Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууна.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр энэ төслийн танилцуулга дээр байгаа Багануурын болон Чойрын дэд станцын 220-ын цахилгаан дамжуулах шугамын нийт урт нь километр нь хэдэн километрээр тооцсон юм бол?

Дээрээс нь үндсэн төлөвлөлтөд орсон байсан төсөл үү?

Тэгээд километрийг хийх дундаж өртөг хэд байдаг вэ? Өртгийг нь.

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүнийг асуулт дээр нэмээрэй. Хариулт хэдэн номер вэ? 5 номер.

Г.Энхтүвшин: Гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яамны Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин.

Багануур-Чойрын цахилгаан дамжуулах агаарын шугам нь 188 километрийн урттай. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан. Төлөвлөлтөд орсон төсөл байгаа.

Төслийн нийт төсөвт өртөг 47 сая ам.долларын төсөвт өртөгтэй төсөл байгаа. 1 километрийн өртөг бол бүс нутаг, тухайн байгалийнхаа тогтоц байршлаасаа хамаараад 600 орчим сая төгрөгийн төсөвт өртөгтэй ийм төсөл.

Р.Сэддорж: Хариулт хэдэн номер вэ? 5.

Б.Дашдаваа: Сайн байцгаана уу?

2022 онд Барилга, хот байгуулалтын яаман дээр зураг хийгдсэн байгаа. Тэгээд ер нь зураг хийгдээд зураг төсөв нь экспертизээр баталгаажсан учраас саяын 47.8 сая долларын өртөгтэйгөөр гарч байгаа.

Чойр, Сайншандын шугам 60 гаруй сая долларын өртөгтэй гарч байгаа. Энэ бол нөгөө зураг газар зүйн байдал, трассын онцлог, тэгээд ямар технологи ашиглаж байгаагаасаа хамаарч байгаа.

Р.Сэддорж: 5 номер гүйцээж хариулъя.

Б.Дашдаваа: Гүйцэтгэлийн шатад нэмэгдэхгүй.

Р.Сэддорж: С.Цэнгүүн гишүүн тодруулж асууя.

С.Цэнгүүн: 1 километр дамжуулах шугамын үндсэн жишиг өртөг байгаа шүү дээ. Бусад төслүүдтэй харьцуулахад.

Тэгэхээр энэ төслөө бусад өмнө нь хэрэгжүүлж байсан төслүүдийн өртөгтэй харьцуулахад Та хэлээд өгч болох уу?

Р.Сэддорж: 5 номер. Хариулт.

Б.Дашдаваа: Ер нь манай яамны харьяа Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн гэдэг газар ерөнхийдөө 1 километр 220-ын 110 киловольтын хүчдэлийн түвшин нь ялгаатай шугамуудын нэгж өртгийг тооцож гаргадаг. Жил болгон.

Энэ дээр ер нь 220 киловольтын шугам дотоодын эх үүсвэрээр явахад 400 гаруй сая, 400-аас 500 сая төгрөгийн байдлаар гарч байгаа. Тийм.

Р.Сэддорж: Асуултад их тодорхой хариулаарай. Өөртөө итгэлтэй хариул л даа. Нэмж хариулах уу? 5 номер.

Б.Дашдаваа: Ер нь ойролцоогоор урьдчилсан байдлаар гаргадаг. Түүнээс яг 1 километр шугамын өртөг ийм байна гэж гарах боломжгүй. Тийм. Боломжгүй.

Энэ бол зураг төсөв хийгдэж байж, экспертизээр орж байж батлагдаж байгаа.

Р.Сэддорж: Их Хурлын чуулган дээр олон гишүүд асуулт асууна. Энэ дээрээ сайн бэлдээрэй. С.Цэнгүүн гишүүн болсон уу? Та тэгвэл микрофон дээрээ хэлчих. Хариулт хангалтгүй гэж үзэж байна. С.Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Эрчим хүчний яамнаас яг тодорхой хариултуудыг гаргаж жишээтэйгээр харуулмаар байна.

Тэгэхээр энэ дээр хариултаа сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Р.Сэддорж: 5 номер уу? 6 номер гэж байгаа юу? Байхгүй байна. 5 номер хариулт.

О.Хуягцогт: Энэ дээр нэмэлт тайлбар өгөхөд. Ер нь гишүүний асуултад бид бас илүү тодорхой мэдээлэл нэмж өгье.

Одоо байгаа мэдээллийн хүрээнд гэх юм бол ер нь Чойр, Сайншанд чиглэлийн 220 киловаттын хоёр хэлхээд цахилгаан дамжуулах агаарын шугам, холбогдох дэд станцуудтайгаа хамтдаа Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилт дээр хэрэгжиж байгаа.

Энэ одоо эхлэлийн шатад байгаа. Нийт төсөвт өртөг нь 75.5 сая ам.доллар. Энэ дээр түрүүн манай мэргэжлийн хүмүүс хариулсан. Энд зөвхөн шугамаас гадна тэр хоёр хэлхээт төв. Мөн тэнд оролцож байгаа дэд станцын өргөтгөл, шинээр барьж байгаа дэд станцуудаас хамаараад төсөвт өртгүүд нь харьцуулахад шууд нийт төсөвт өртгийг нь километр харьцуулахад бас ялгаатай зүйлүүд байгаа.

Дээр нь санхүүжүүлж байгаа байгууллагуудаас зээлийн нөхцөл тавьж байгаа. Илүү нөгөө байгаль орчинд ээлтэй.../минут дуусав/

Р.Сэддорж: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууна.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Багануурийн 220 киловольтын шугамыг хоёр хэлхээтэй шинэ шугамаар барих энэ төсөл бол маш ач холбогдолтой төсөл. Олон жилийн турш яригдаж байсан. Яг одоогоор 220 киловольтын нэг хэлхээтэй бетон тулгууртай шугамаар олон аймаг, сумд цахилгаанаар хангагддаг. Их найдваргүй.

Тэгэхээр үүнийг барих асуудал их олон жил яригдсан. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор гурван асуулт байна л даа.

Нэгдүгээр асуулт. Ерөнхийдөө гадаадын зээл, тусламжаар цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих, ялангуяа энэ төслийн хувьд жишээ нь зээлийг хэдэн жил хөөцөлдөж байж бүтээсэн бэ? Одоо анх яригдаж эхэлснээс хойш.

Тэгэхээр энэ зээл бүтээсэн хугацааг нэгдүгээрт надад хэлж өгөөч.

Хоёрдугаар асуудал. Энэ төслийн хүрээнд яг Багануур, Чойр дэд станцууд дээр яг ямар ажлууд хийгдэх вэ? Одоо 220 киловольтынх нь хуваарилах байгууламжийг хэдэн гаргалгаагаар өргөтгөх вэ? 110 дээр нь өргөтгөх юм хийх үү? Релей хамгаалалт, автоматик дээр бас өргөтгөлийн ажлууд хийгдэх үү гээд.

Гуравдугаарт, мэдээж зээл, тусламжаар авч байгаа хөрөнгийн асуудлыг нөхөх асуудал. Хөрөнгөөр нөхөх асуудал байгаа.

Тэгэхээр одоо бид эх үүсвэрийн хувьд гадаадын зээл, тусламж авахаар. Тухайн төсөл дууслаа. Маргаашаас нь эхлээд эх үүсвэрийн хувьд орлого олоод эхэлдэг учраас нөхөгдөөд эхэлнэ. Гэтэл цахилгаан дамжуулах агаарын шугамын хувьд ямар нэгэн орлого олно гэсэн ойлголт байхгүй.

Тэгэхээр энэ зээлийн хувьд зээлийг нөхөх асуудал яаж явагдаж байгаа вэ? Одоо хаанаасаа, ямар орлогоосоо энэ шугам дээр авч байгаа зээлийг нөхөх асуудал яригдах вэ гээд ийм гурван асуулт байна.

Р.Сэддорж: Хариулт 5 номер.

О.Хуягцогт: М.Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт.

Энэ төслийн хувьд техник, эдийн засгийн үндэслэл нь бол 2022 онд хийгдэж баталгаажиг байсан. Ингээд зээлийн хэлэлцээр нэлээн хэд хэдэн шатыг давж өнгөрсөн.

Сая Б.Жавхлан сайдын танилцуулгад гарснаар Дэлхийн банктэй хамтарсан ажлын хэсэгт Засгийн газрын ажлын хэсэг ажиллаж сая өнгөрсөн оны 11 дүгээр сард, 2024 оны 11 дүгээр сард Засгийн газрын хуралдаанаар эцэслэж шийдвэрлэсэн байгаа. Ингээд Их Хурал дээр хэлэлцэж зохих шийдвэр гаргах процесс явж байна.

Тэгэхээр 2025 он гэхээр 2 жил, 3 дахь жилдээ ийм үргэлжилж байгаа процесс байна.

Мөн тэр тарифын нөхөн төлөх хугацаатай холбоотой асуудлууд дээр бас энэ дээр нэмэлт судалгаан дээр хийгдсэн. Зээл эргэн төлөгдөхөд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит компани маань дамжуулдаг. Эрчим хүчний зохицуулах хорооноос дамжуулалтын өртгийг тооцож авдаг.

Энд бид яам болон эрчим хүчний зохицуулах хороо, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компаниас ер нь энэ тарифын дотоод тарифт тооцож байгаа дизайнаа бид бас өөрчлөх ажлууд хийгдэж байгаа.

Энэ дээр яваандаа Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит компанийн орлогыг дунд хугацаанд төсөөлөх бололцоотой болгох замаар тарифын дизайныг өөрчлөх замаар эргээд энэ зээлийн эргэн төлөлтийг шийдэх ийм асуудлыг ажлын хэсэг дээр судалж бид ярилцсан байгаа.

Техник, тэр дэд станцтай холбоотой нэмэлт мэдээллийг манай Б.Дашдаваа захирал нэмж өгнө.

Р.Сэддорж: 5 номер.

Б.Дашдаваа: Багануур, Чойрын одоо байгаа шугам нь 220 киловольтын нэг хэлхээтэй. Түрүүн М.Энхцэцэг гишүүн хэллээ. Бетон тулгууртай ийм шугам байгаа.

Энэ 207 гэдэг нэртэй шугамаар 6 аймгийн 60 гаруй сум, суурин үндсэндээ тэжээгддэг. Ганц хэлхээтэй ийм шугамд засвар үйлчилгээ хийх, ямар нэгэн аваар осол гарахад нөөц тэжээлийн эх үүсвэр байхгүй ийм хүндрэлтэй байсан. Энэ бол 2007, 2008 оноос хойш ямар нэгэн байдлаар шинэчилье. Хоёр хээтэй шугамыг өөр троссоор барья гэдэг энэ асуудлыг Эрчим хүчний яам бусад холбогдох байгууллагуудад байнга тавьж ирсэн.../минут дуусав/

Р.Сэддорж: 5 номер гүйцэтгэгч хариулья.

Б.Дашдаваа: Тэгэхээр энэ 2007, 2008 оны үеэс яваад өнөөдрийн түвшинд хүрч байгаа. Одоо энэ маш чухал.

Ер нь энэ говийн бүс, өмнөд бүс, зүүн бүсийн гол зангилаа хамгийн том станц нь Чойр станц байгаа. Чойр станц шинэчлэгдсэн. 200 мегаваттын 2 трансформатортай, 400 мегаваттын чадалтай хамгийн том станц байгаа. Манай Монголын.

Багануурын станц бол мөн зангилаа станц болохоор ийм дүр зурагтай болсон. Ингээд Чойр дээр 2 гаргалгаа шинэчилнэ. Багануур дээр гаргалгаа шинэчилнэ. Дээрээс нь схемийн өөрчлөлттэй байгаа. Системийг өргөтгөх. Ер нь

4 системтэй болох ийм дүр зураг харагдаж байгаа. 20 гаруй ричактай болно. Чойр одоо 110-ын 18 гаргалгаатай.

Р.Сэддорж: Асуулт нь их тодорхой хариулахгүй бол хугацаа чинь амжихгүй байна.

Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн. М.Энхцэцэг гишүүн тодруулъя.

М.Энхцэцэг: Саяын асуултууд болж байна. Би дахиад хоёр юм асуучихъя гэж бодож байна.

Ерөнхийдөө энэ шугамыг дотоодын хөрөнгө оруулалтаар хэрвээ хэрэгжүүлэх юм бол бараг 1 километр нь бол 400 сая орчим, 400-аас 500 гэж байна.

Тэгэхээр энэ гаднын зээл, тусламжаар хэрэгжүүлэхээр бараг 1 километр нь 500-аас 600 сая гээд өсөж байгаа гэсэн. Тэр дүнг танилцуулаач ээ гээд сая С.Цэнгүүн гишүүн бас асуугаад байх шиг байна. Үүнийг тодорхой гаргавал зүгээр юм болов уу гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, хэрэгжүүлэх хугацаа. Бид дотоодын хөрөнгө оруулалтаараа хэрвээ энэ шугамыг барих юм бол бараг нэг жилийн дотор хэрэгжүүлчихнэ. Зүгээр гаднын гаднын зээл, тусламжаар хэрэгжүүлэхээр бараг тендер нь хүртэл нэг жил үргэлжилдэг. Нөгөө тендерээ шалгаруулчихаад банк руу явуулдаг. Хэрвээ банк зөвшөөрвөл нөгөө тендерээ үргэлжлүүлдэг гээд.

Тэгэхээр энэ төсөл одоо энэ зээлээр ингээд хэрэгжүүлэхэд ер нь хэдий хугацаанд хэрэгжинэ гэж бодож байна? Нэг жилийн дотор хэрэгжих үү, эсвэл 1-ээс 2, 3 жил үү гэж. Энд тодорхой хариулт өгөөсэй гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, дотоодын компаниуд гүйцэтгэх үү, эсвэл зээл авч байгаа гаднын компани гүйцэтгэнэ гэсэн бас нэг.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт. Хэн хариулах вэ? 4 номер. Сангийн сайд.

Б.Жавхлан: Тийм. М.Энхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Ер нь бид зээл авахад бэлтгэл ажил одоо өөрөөр хэлбэл Их Хуралд орж иртлээ ер нь хоёр чиглэлийн бичиг баримтыг гол суурь болдог байгаа юм.

Нэгдүгээрт, Засгийн газрын яг Их Хурлаар батлагдсан 4 жилийн төлөвлөгөөнд орсон уу, үгүй юу. Зээл авах гэж байгаа цаад институц манай хоёрын хоорондын дунд хугацааны төлөвлөгөөнд орсон уу, үгүй юу. Тэр аль алинд нь бүгдэнд нь орчихсон явж байгаа.

Яг энэ тухайлан энэ Багануур, Чойрынх дээр бид жилийн өмнө хүсэлтээ өгөөд, нэг жил хэлэлцээр хийгээд. Ер нь нэг иймэрхүү л явдаг юм. Энэ ч харин

хурдан бүтлээ. Та бараг гадарлаж байгаа байх. Бараг 2 жил, 3 жил болдог. Тийм ээ. Энэ ч харин хурдан бүтлээ.

Одоо дараагийнх нь Дэлхийн банкны “Эрчим хүч-3” төсөл дотор Мандалговь 12 байж байгаа. Энэ дүн нь бас ойролцоо ийм дүнтэй явж байна. Хэлэлцээр бас яг үргэлжилж байна. Энэ удаа арай амжсангүй. Хавар чуулган эхлэнгүүт Мандалговь, Арвайхээрийг оруулж ирнэ. Нэг иймэрхүү байдалтай явж байна. Тийм.

Ач холбогдлыг нь одоо та.../минут дуусав/

Р.Сэддорж: Дараагийн нэмж хариулт. 5 номер.

О.Хуягцогт: М.Энхцэцэг гишүүний сүүлийн асуултад нэмж тодруулахад. Ер нь энэ зээл маань Дэлхийн банкны санхүүжилттэй. Тэгээд Дэлхийн банкны журмаар явна.

Энд ямар нэг өмнө хоёр талт хэлэлцээр шиг тухайн улсынхаа гүйцэтгэгч компанийг оролцуулах ийм нөхцөл байхгүй. Дэлхийн банкны журмаар хязгаарлалтад ороогүй гишүүн орнууд бүгд оролцох нээлттэй байгаа.

Төсөл хэрэгжих хугацааны хувьд олон улсын нээлттэй тендер шалгаруулалт зарлагдана. Энэ тендер шалгаруулж гэрээ байгуулагдсанаас хойш 2 жилийн хугацаанд гүйцэтгэх ийм нөхцөлтэй байгаа.

Харьцуулсан тэр мэдээллийг бид бас нэмж гаргаж төсөл болгон дээр хийгдэж байгаа ажлын объектоор задаргаатай нь бас С.Цэнгүүн гишүүн, М.Энхцэцэг гишүүнд гаргаж мэдээлэл өгье. Ийм асуултууд байгаа. Тийм ээ.

Р.Сэддорж: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Миний асуух гэж байсан асуултыг ерөнхийдөө С.Цэнгүүн гишүүн, М.Энхцэцэг гишүүн хоёр асуучихсан.

Тэгэхээр яах вэ, гол нь зүгээр 47 сая долларыг 188 километр хуваахаар ойролцоогоор километр 850 сая төгрөгийн өртөгтэй болоод байна л даа.

Тэгэхээр түрүүн тайлбарлаад байгаа хэчнээн дэд станц байгаа юм? Тэр газар зүйн нөхцөл байдал нь ямар байгаа юм? Тэгээд гэрээний өөр ямар онцлог нөхцөлүүд байдаг юм. Тэрийгээ оруулаад оруулаад бодохоор дотоодын бусад өмнө нь хэрэгжүүлсэн төслүүдтэй харьцуулахад ямар байдалтай байгаа юм? Олон улсын хэрэгжүүлж байгаа төслүүдтэй харьцуулахад ямар байдаг юм? Ийм харьцуулалттайгаар нь бичгээр өгөөч ээ гэсэн ийм санал байна.

Р.Сэддорж: Бичгээр авахаар болчихлоо. Тийм ээ.

Энэ дээр хариулах юм уу, үгүй юу? 5 номер хариулах гээд байх шиг байна.

Б.Дашдаваа: Түрүүн М.Энхцэцэг гишүүн өөрөө бас хэллээ. Цахилгаан дамжуулах агаарын шугам дээр хөрөнгө оруулах юм уу, хөрөнгө тавих маш хүнд. Маш олон зураг төсөл, төсөв хийгдсэн байгаа. Олон жил хөөцөлдөж байгаа. Энэ хаана ч тавигддаггүй. Харин сая Б.Жавхлан сайдын хэлдгээр маш хурдан энэ бүтээд явж байгаад нь баяртай байгаа.

Тийм учраас тэр харьцуулах гээд байгаа сүүлд 220-оор орсон шугам, дэд станц бараг байхгүй. Одоо эхнийх нь л энэ Чойр, Сайншанд явах гэж байх шиг байна. Тийм.

Тэгэхээр энэ хөрөнгө нь олдохгүй. Тийм.

Р.Сэддорж: Мягмарсүрэнгийн М.Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Магистрал буюу 220-ийн өндөр хүчин чадлын шугам тавихыг бол дэмжиж байгаа.

Ер нь эрчим хүчний хангамжийг сайжруулахын тулд эх үүсвэрүүд хаана байх юм гэдгийг тооцохоос гадна хооронд нь дамжуулах шугамуудыг цаашид маш ихээр барих хэрэгтэй. Тэгж байж энэ чинь том нэгдсэн сүлжээнд орно шүү дээ. Монгол Улс. Зөвхөн бид авто зам, төмөр замаар л холбох л юмыг дэд бүтэц гэж ойлгоод байдаг. Гэтэл үүний цаана чинь шилэн кабель, энэ цахилгаан дамжуулах шугам гээд маш өндөр ач холбогдолтой агаарын шугам.

Тэгэхээр үүнийг дэмжиж байгаа. Харин үнийн дүнгийн хувьд гишүүдийн хэлдэгтэй санал нэг байна. Үүнийг дахин хэлэлцээр хийх боломж байдаг уу? Эсвэл өөр одоо тийм төвөгшил байна уу? Эсвэл арай олон дэд станц байна уу? Тийм ээ. Дэд станцад бол нэлээн өндөр өртөгтэй байдаг шүү дээ. Магадгүй олон суурьшлын бүсүүд, олон үйлдвэрүүд, олон зангилаа өртөө гээд зүйлүүд дээр бас ийм дэд станцууд олноор баригдвал, хуваарилах байгууламжууд олноор баригдвал мэдээж энэ дээр тодорхой төсөвт өртөг нэмэгдэнэ л дээ.

Тэгээд үүнийгээ задалж харуулахгүй бол зөвхөн 188 километр шугам юм шиг л ингэж ойлгогдоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүний талаар ийм дэлгэрэнгүй танилцуулгыг би бас бусад гишүүдтэй адил авъя гэж бодож байна. Яагаад гэхээр цаашид Багануураас Өндөрхаан, Өндөрхаанаас Чойбалсан гээд ийм 220 шугам тавих ажил Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөрт байгаа шүү дээ. Манай “Алсын хараа”, том бодлогод ч гэсэн байгаа.

Тэгэхээр ингэж цахилгаан станцыг чинь хаана барьдаг вэ гэхээр байрлалыг нь сонгохдоо

- ▶ Нэгдүгээрт, нүүрсний нөөц,
- ▶ Хоёрдугаарт, усны нөөц,
- ▶ Гуравт нь, хэрэглэгч

гэдэг гурван тулгуур зүйл дээр уялдуулж барьдаг учраас цаашдаа Дорнодын бүсэд, Өмнөговийн бүсэд, Багануурын бүсэд цахилгаан станцууд мэдээж баригдана.

Тэгэхээр үүний найдвартай ажиллагааг хангахгүй бол цаашдаа бид метро барина, олон улсын нисэх буудлууд барина. Томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд чинь цахилгааны хувьд 3-аас доошгүй найдвартай эх үүсвэртэй байх.

Тийм учраас зүүн бүсэд гэхэд ганцхан Дорнод станцтай гэдгээрээ найдвартай биш. Дахиад төвийн бүсээс хажууд нь хоёр дахь станц барьдаггүй юм гэхэд төвийн бүсээс өндөр хүчдэлийн шугамаар холбогдох гэдэг юм уу энэ зүйл явах учраас үүнийг нэг бүхэлд нь бас л ингээд нэг ийм эрчим хүчний шугам сүлжээний хувьд том стратеги бид гаргах хэрэгтэй байх. Хоёр улсыг дамнасан эрчим хүчний шугам байх юм уу, дотооддоо ямар сүлжээ байх юм гээд. Энэ дээр олон нийт бол ямар ч ойлголцогүй байгаа шүү дээ. Бид ч гэсэн бас мэдээлэл багатай байна.

Тэгэхээр үүнийг эхлээд ач холбогдлыг нь ойлгуулж, цаашдын төлөвлөлт дээр нь энэ зүйлийг бизнесменүүд үйл ажиллагаандаа үүнийг мэдээлэлтэй болох нь хамгийн өндөр ач холбогдолтой шүү.

Тийм учраас аймаг болгонд станц барьж чадахгүй юм гэхэд том хүчин чадлын ийм өндөр хүчдэлийн шугамаар, 290 шугамаар холбох нь маш чухал.

Тэгэхээр үүнийг цаашид анхаарч ажиллаач ээ.

Р.Сэддорж: Саяын мэдээллийг гишүүд бүгдээрээ авъя гэсэн ийм хүсэлт өгч байна. Эрчим хүчний яам. Энэ мэдээллээ сайн өгчихвөл эхэндээ амар шүү дээ.

Тэгэхгүй бол дараа нь. Үүнийг протоколд тэмдэглүүлж, манай ажлын алба бас энэ дээр анхаараарай.

Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?
С.Цэнгүүн гишүүнээр нэр тасаллаа. С.Цэнгүүн гишүүн үг хэлье.

С.Цэнгүүн: Тэр эрчим хүчний салбарт бид дандаа шинэ эх үүсвэрүүдийг яриад, ерөөсөө дамжуулах шугамын асуудлаа дандаа орхигдуулж ирсэн.

Тэгээд ер нь Монгол Улсын хэмжээнд хараад үзэхээр 220-ийн шугам маш цөөхөн байгаа.

Тэгэхээр энэ маань өөрөө маш том хөгжил дэвшлийн эхлэл байх гэж харж байгаа учраас энэ төслийг дэмжиж байгаа.

Тэгэхээр бид ер нь одоо энэ санал хураалт бас явагдах байх. Тийм ээ.

Тэгэхээр гишүүдийнхээ ирцийг өндөр байлгах тал дээр Байнгын хорооны дарга маань анхаараад өгөөч ээ гэж хүсмээр байна. Яагаад гэхээр энэ нэлээн чухал ач холбогдолтой төсөл байгаа шүү.

Р.Сэддорж: 188 километр, 220 шугам. Тийм ээ. 47 сая долларын зээл гэж ойлгож байгаа.

Европын сэргээн босголтын банк. Тийм ээ. Олон улсын сэргээн босголтын хөгжлийн банк. Дэлхийн банкны харьяа энэ байгууллагаас авч байгаа зээлийн хэлэлцээр байна.

Тэгээд Эрчим хүчний яам бэлтгэлтэй. Цаашдаа асуудалд бэлтгэлтэй орж ирэх хэрэгтэй байна. Тэгээд танай яамны асуудлууд бол энэ Монголд нэлээн сенсацтай байна.

Тийм учраас Та бүхэн маань энэ дээрээ. Тэгээд танай яам эрчим хүчний хомсдолд бүх юмаа зохицуулж чадахгүй байж бас нөгөө сэргээгдэх эрчим хүчээ яахаа бас өдий болтол шийдээгүй байгаа.

Тэгэхээр ялангуяа энэ аймаг, хөдөө орон нутгууд чинь сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэе гээд маш олон саналууд аймгуудад ирдэг.

Тэгэхээр энэ дээр бас Та бүхэн маань энэ завшааныг ашиглаж дахин дахин хэлье. Үүнийгээ нэг тийш нь гаргаад дэлхий нийттэй хөл нийлүүлэн энэ сэргээгдэх эрчим хүчээ давхар ашиглаад явах талаас нь Та бүхэн маань амжилт гаргаарай гэдгийг энд хэлье.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Санал хураалт.

Монгол Улс болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Монгол Улс болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан танилцуулна.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

Хуралдаан 2 цаг 02 минут үргэлжилж, 15 цаг 15 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД